

МОНГОЛЫН
АНАГААХ
УХААН

1993*3

Үргэлжлэл Түрүүч нь №2-т

4. Бадрахын Бурмаа Эрүүл ахуй халдварт нян судлалын улсын институтын эрдэм шинжилгээний ажилтан.

Сэдэв: БНМАУ-ын металл боловсруулах мэргэжил эзэмшиж буй өсвөр үеийнхний сургалтын нөхцөл, эрүүл мэндийн байдлын эрүүл ахуйн үнэлгээ.

Хэзээ, хаана хамгаалсан: 1992 оны 4 дугээр сарын 23
Москва.

БНМАУ-ын нөхцөлд Техник мэргэжлийн дунд сургуульд суралцаж металл боловсруулах үндсэн мэргэжил эзэмшиж буй өсвөр үеийнхний сургалтын нөхцөл, эрүүл мэндийн байдал, бие бялдрын өсөлт, хөгжлийн хөгжил зүйг анх удаа сургалтын З жилийн туршид судэлж өсвөр үеийнхний сургалтын нөхцөл, дэглэм, эрүүл мэндийн байдалд физиологи - эрүүл ахуйн үнэлгээ өгч, хот хөдөөгийн өсвөр үеийнхэн металл боловсруулах үндсэн мэргэжлийг эзэмших сургалтын нөхцөлд дасан зохицох онцлог байдлыг илрүүлэв.

5. Санжжавын Цэцэгмаа --- Анагаах ухааны их сургуулийн аспирант

Сэдэв: «Монгол ардын эмнэлэгт өргөн хэрэглэгдэж байсан зарим зүйлийн ортузын фитохимийн судалгаа».

Хэзээ, хаана хамгаалсан: 1992 оны 4 дугээр сарын 23
Улаанбаатар.

Судлаач манай оронд их гарчсан, арлын эмнэлэгт өргөн хэрэглэж ирсэн ортуузын төрлийн ургамлуудаас З зүйл (боргоцойрхуу ортууз, уст хөөнгө ортууз, зөвлөн өргөст ортууз) -ыг сонгон авч тэлгээрийн биологийн идэвхт бодисыг анагаах ухааны практикт ашиглах боломжтойг нь судалсны зэрэгцээ манай орны нөхцөлд ургамлын түүхий эдээс биологийн идэвхт бодисуудыг дан байдлаар ялган авах, цэвэршиүүлэх, тэлгээрийн физик, химийн шинж чанарыг тодорхойлох, бүтэц байгууламжийг нь хими, хроматографи, спектроскопийн аргуудыг хослуулан эшиглаж тогтоох, улмазж анагаах ухааны практикт шинжлэх ухааны үндэслэлтэйгээр нэвтрүүлэх зорилгын стандарт, технологийн заавар боловсруулсан бөгөөд дээрх З ургамлуудаас биологийн идэвхт 12 таан бодис (4 алкалоид, 8 флавоноид)-ыг ялган авч бүтэц байгууламжийг тогтооены З нь шинэ алкалоид байлаа.

МОНГОЛЫН АНАГААХ УХААН

ЭМЯ, ЭМЧ НАРЫН ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ
НИЙГЭМЛЭГИЙН ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭ-ПРАТИКИЙН
УЛИРАЛ ТУТМЫН СЭТГҮҮЛ

дахь жилдээ

№ 3 (34)

1993 ОН

СУДАЛГАА ШИНЖИЛГЭЭ

Г. Зуунай, Н. Сюунчимэг Хүний бие бялдрын зарим үзүүлэлт	3
Д. Энхтуяа Сургуульд сурхад бэлэн болсон байдлыг 6 настай хүүхдийн туршилтын цэцэрлэгг судалсан зарим үр дүн	5
Ш. Орсэо 1—3 настай хүүхдийн бие бялдрын хөгжлийн хэвийн хэмжээ	11
Б. Сүхбаатар, С. Мажигсүрэн, Д. Намсрай Эхийн сүүний ханаагүй хүчлүүдийн хөбөрчийн холбооны байршил ба түүний цис, транс изомери байгууламжийг судалсан нь	14
П. Онхуудай Элэг цэсний архаг эмгэгийг дүрслэл оношлогооны аргаар оношлох боломж, хязгаар чиг баримжаа	17
Ш. Жадамбаа, Ц. Намсрай Нярай хүүхдийн эрт амлуулах шинжлэх ухааны үндэс	23
Г. Батмөнх Монгол хүний цусны АВО бүлгийн тархалтыг судалсан нь	25

ЛЕКЦ ТОЙМ ЗӨВЛӨГӨӨ

П. Яисан Монгол улс дахь малчдын өвчлөл эмнэлэг үйлчилгэгний зохисн байгуулалт	32
Г. Цэрэнжигмид Ариун цэврийн соёлын уламжлалыг судлах асуудал	35
Ю. Жинсмаа Энкефалин систем	40

АСУУДАЛ ДЭВШҮҮЛЖ БАИНА

Ч. Дондог Монгол улсын хүн ам зүйн түүхэн хөгжлийн үе шаталын асуудалд	43
И. Санжаадорж Зах зээл эмчийн ёс суртахуун	46

MONGOLIAN MEDICAL SCIENCES
QUARTELY JOURNAL OF THE MINISTRY OF HEALTH
MONGOLIA AND THE Scientific SOCIETY OF
MONGOLIAN PHYSICIANS

34-th year of publication №—3 (84) 1993

CONTENTS

ORIGINAL ARTICLES

. G. Zuunai, N. Ojuntschimeg.	
Some physical characteristics of Mongolian population	3
D. Enkhtuya. Results of study on psycho — physiological preparedness for school of 6 years children in an experimental kindergarten.	5
Sh. Orosoo. Physical development of children under 3 years	11
B. Suchbaatar, S. Majigsuren, D. Namsrai. Study of double connection place of unsaturated acid of mother's milk and its cysteanc isomer composition	14
P. Onchuudal. The significance and diagnostic possibilities of imaging diagnostics procedures for chronic Liver—and Bile disease.	17
Sh. Jadambea, Z. Namsrai. Scientific groundness of early initiation for breastfeeding after birth	23
G. Batmunch. Distribution of the ABO (H) blood group markers in mongolian population	25

LECTURES, REVIEWS AND CONSULTATIONS

P. Vansan Organisation of Health services to Herdpeople in Mongolia	32
G. Tserenshigmed. On the study of traditional sanitary culture of mongolia	35
Yu. Jinsmaa. Enkephalin system.	40

OPINION

Ch. Dondog On the Stages of Historical Demographic development in Mongolia	43
I. Sanshaador Market economy and Morals of Health professionals	46

Судалгаа шинжилгээ

ХУНИЙ БИЕ БЯЛДРЫН ЗАРИМ ҮЗҮҮЛЭЛТ

Г. ЗУУНАЙ (УИХ-ын гишүүн, дэд доктор) Анаагаах Ухааны хүрээлэн

Аливаа улс орны өрөнхий нөөц, баялгийн чухал эх үүсвэр бол ард түмний нь эрүүл мэндийн үзүүлэлт болдгийг хүн төрөлхтний үе үеийн түүх бэлхнээ гэрчилнэ.

Ард түмний эрүүл мэндийн өрөнхий үзүүлэлтийг дотор нь хүн ам зүйн, эрүүл мэндийн ба бие бялдрын (өвчлөлийн, тахир дутуугийн, нас баралтын) гэж ангилдаг. Тэдгээр нь тус тусдаа өвөрмөц үзүүлэлтүүдтэй, судлах арга нь өөр өөр бие дэасан шинжлэх ухаан болтлоо хөгжсөн билээ.

Эдгээрээс биений хөгжлийн буюу бие бялдрын (физик) үзүүлэлтүүд нь улс үндэстэн бурийн өвөрмөц онцлогтой, тэр ч байтугай тодорхой дэвсгэр нутаг, үндэстэн ястан, овог удмынханд хүртэл өөр байдгийг тэмдэглэвэл зохино.

Манай оронд хүн амын хамгийн тогтвортой бодит үзүүлэлт болох биений хөгжлийн буюу бие бялдрын үзүүлэлтүүдийг судлах талаар аллаг цоог ажлууд хийгдэж байсан боловч олон асуудалд хариу өгөгдөөгүй онгорхой, поорхой хэвээр байсаар байна.

Хүн амын бие бялдрын үзүүлэлтүүд бол удамшил, эхийн хэвлэлий дэх үеийн хөгжлийн онцлог зэрэг дотоод шалтгаант

(эндогенный), хүчин зүйл мөн гадаад шалтгаант (экзогенный) хүчин зүйл болох байгаль цаг уурын ба нийгэм эдийн засгийн цогцолборуудын шууд ба шууд бус тусгалын нийлбэр үр дүн болж хүн амын тухайн нас, хүйсний тодорхой бүлгүүдийн биений хөгжлийн онцлогийг тусгаж байдал толь үзүүлэлт юм. Эдгээрээс хамгийн түгээмэл нь биений өндөр, жин, цээжний тойргийн хэмжээ гэх мэт биет, амьсгалын багтаамж, цусны даралт зэрэг үйл зүйн үзүүлэлтүүд арай илүүтэй судлааджээ.

Манай оронд хүүхэд болон насанд хүрэгчдийн бие бялдрын хөгжилт, тэдний цусны даралт өөрчлөгдэх өвчин хүүхэд байх үеэс нь аажмаар эхэлдэг болох тухай Ч. Чултэмдорж (1958, 1961), Ц. Дугарням (1959), Х. Лхагжав (1972), Но. Дондог (1973), Д. Батчулуун (1974), Г. Батмөнх (1981), А. Өлзийхутаг (1990), Ц. Дашдаа (1991) зэрэг мэдэмтэд судалгаа хийж, зарим дүгнэлт өгсөн байна. Гэвч хүн ам зүй, хүн амын эрүүл мэнд, эмнэлэг хангамжийн үзүүлэлтийг хооронд нь уялдуулж, дүгнэлт хийсэн судалгаацын ажил ховор байгаа билээ.

Иймээс бид Анаагаах Ухааны Хүрээлэнгийн эрдмийн зөвлөллөэр батлагдсан аргачлалын дагуу зарим судалгаа хийж дараах зорилгыг шийдвэрлэхийг оролдов. Үүнд:

1. Улаанбаатар хот, Говь-Алтай аймгийн судалгааны түшиц газруудад 8—17 настай сургуулийн сурагчид болон насанд хүрэгчдийн цусны даралтын хэмжээг нас, хүйсээр тогтоок.

2. Судалгаанд хамрагдсан янз бүрийн насны хүмүүсийн биений жин, ондрийн хэмжээг бус нутгаар нь тогтоох.

3. Тэдгээрийн цусны даралт, биений жин, ондрийн үзүүлэлтийн хоорондын хамаарлыг судлах явдал байв.

Судалгаанд хамрагдагсдаас тодорхой тооны хүмүүсийг тохиолдлын аргаар түүврэлэн авч, цусны даралтыг суугаа байрлалд баруун гартийн Риброгийн аппаратаар үзэж, биений жинг эмнэлгийн зориулалттай Фербенксийн дэнсээр, биений ондрийг зориулалтын багажаар тус тус хэмжилт хийв.

Судалгаанд нийт 5001 хүн хамрагдсан бөгөөд 56,9% эрэг тэй, 43,1% эмэгтэй; 51,1% хот, 48,9% хөдөө; 39,3% хүүхэд, 60,7% насанд хүрэгсэд байлаа.

Судалгааны материалд статистикийн хувилбарт эгнээний аргаар арифметикийн дундаж, дундаж квадрат казайлтг, дундаж алдааг ($M \pm t \pm m$) тооцож, корреляцийн шинжилгээний аргаар регрессын шугаман тэгшитгэл ($y = M + R$), корреляцын хамаарлын коэффициент (χ) зэрэг үзүүлэлтийг бус нутаг,

нас хүйс дутамд тодорхойлж, үзүүлэлтийн магадлалыг Студентийн аргаар шалгав.

Бидний судалгаагаар 8—17 настай сурагчдын цусны их даралтын дундаж хэмжээ (системол) $99,7 \pm 0,88$ мм МУБ, бага даралтын дундаж хэмжээ (диастол) $73,5 \pm 0,89$ мм МУБын хэмжээтэй байв.

Сургуулийн сурагчдын биений жин, ондэр нас ахих дутам, нэмэгдсээр 17 настай хүүхдийн биений жин $55,3 \pm 0,13$ кг, биений ондэр $165,1 \pm 0,92$ см байв. Насанд хүрэгсдийн хувьд 18—49 насанд биений жин тогтмол осож дунджаар $60,3 \pm 0,39$ кг, биений ондрийн дундаж хэмжээ $162,6 \pm 0,40$ см байлаа.

Судалгааны үндсэн зорилт болох хүний цусны их, бага даралт нь биений жин, ондрээс хэрхэн хамааран өөрчлөгдэж байгаа байдал, хамаарлын хүч ямар байгааг регрессын тэгшитгэл, корреляцын хамаарлын коэффициентын аргаар тооцож үзэхэд дараах байдал тай байв. Үүнд: 8—17 настай сурагчдын цусны их даралтын биений жинтэй харьцуулахад сүл ($\chi = 0,46$) дунд зэргийн шууд хамааралтай, ондрийн хамаарал нь мэдэгдээм ондэр ($\chi = 0,52$) дунд зэргийн шууд хамааралтай байлаа. Дээрх насны сурагчдын бага даралт нь биений жингийнхээ ондертэй сүл ($\chi = 0,32$, $\chi = 0,24$) бага зэргийн шууд хамааралтай байв. Тухайлбал 8 настай хүүхдийн биений дундаж жин 22,2 кг, биений ондрийн дундаж 123,5 см байсан бөгөөд их даралт нь биений ондрээс хүчтэй

(Ч=0,88) шууд бага даралт нь сул (Ч=0,26) дунд зэргийн шууд хамаарлтай байлаа.

Регрессын тэгшитгэлээс үзэхэд ($y=123,4 \pm 1,89x$) уг насын хүүхдийн биений өндөр 1 см-ээр нэмэгдэхэд их даралт 1,89 мм МУБ-аар бага даралт ($y=123,4 \pm 0,69x$) 0,69 мм МУБ-аар нэмэгдэж байна.

Насанд хүрэгсийн тухайд тэдний нас ахих дутам тухайлбал 30—59 насын хүмүүсийн цусны их даралт нь биений жингээс хүчтэй шууд хамаарч байгаа (Ч=0,56) онцлог ажиллагдаж байна. Дээрх насын хүмүүсийн биений жин 1 кг-аар нэмэгдэхэд $y=62,4 \pm 1,38x$ их даралт 1,38 мм МУБ-аар, бага даралт 0,24 мм МУБ-аар тус тус нэмэгдсэн байна.

Судалгаанаас дүгнэлт хий-

хэд Монгол хүний биений жин, өндөр нь цусны их, бага даралтаас дунд зэргийн хүчтэй шууд хамааран өөрчлөгддэг зүй тогтолтой байхын зэрэгцээ 8—17 насын хүүхэд залуучуудын биений өндөр нь их даралтаас, насанд хүрэгсийн биений жин их даралтаас тус тус шууд хамаарлтай байна. Судалгааны дунд янз бүрийн нас, хүйтэй хүмүүсийн бие бялдрын үзүүлэлтийг (жин, өндөр) тэдний үйл ажиллагааны (цусны даралт) үзүүлэлттэй холбон судалж хэвийн хэмжээг тогтоох, тэгснээрээ өвчин эмгэгийн үед гарах өөрчлөлтийг мэдэх, шинжилгээнд үнэлгээ өгөх, онош тогтоох, эмчилгээний тактикийг боловсруулахад чухал ач холбогдолтой байж болох юм.

СУРГУУЛЬД СУРАХАД БЭЛЭН ХҮҮХДИЙН ТУРШИЛТЫН ЦЭЦЭРДЭГ СУДАЛСАН ЗАРИМ УРДЫН АМЖИЛТААСАА
Д. ЭНХТҮЯА Боловсролын хүрээлэн

Хүүхэд сургуулийн эхлэн сургах үйл ажиллагаанд бие бялдар, тооуны хөгжлийн хувьд бэлэн болсон байх ёстой. Энэ нь амжилттай суралцах үндэс болдог.

Өнөөдөр дэлхийн ихэнх оронд зохион байгуулалттай сургах насыг 5—6 нас гэж тогтоон, анхан шатны боловсрол олгож байна.

Хүний бүхий л үйл ажиллагаа нь тухайн хүний бие эрхтэний өвөрмөц үйл ажиллагааны төвшингөөр тодорхойлогддог.

БОЛСОН БАЙЛЫГ 6 НАСТАЙ ХҮҮХДИЙН ТУРШИЛТЫН ЦЭЦЭРДЭГ СУДАЛСАН ЗАРИМ УРДЫН АМЖИЛТААСАА

Энэ төвшин нь хүний ахуй амьдрал, хоол уид, орчин тойрны нөлөөллөөс шууд хамааран эрүүл чийрэг, өвчин эмгэгтэй болох, насыхаа байвал зохих хөгжлийн төвшингөөс доогуур байх, эрт отлөх явдал үүсч бий болно.

Иймд аливаа үйл ажиллагаанд хүний бие эрхтэний өвөрмөц үйл ажиллагаа чухал үүрэгтэй.

Сургаж эхлэх насыг зөв тогтоохын тулд «суралцах үйл ажиллагаанд хүүхэд бэлэн болсон эсэх»-ийг тусгай шалгуу-

раар тогтоодог. Олон оронд сүүлийн 15—20 жилд судлаачид энэ чиглэлээр эрчимтэй ажиллаж байгаа боловч нэгдмэл тайлбар хараахан гараагүй, өөр өөрийнхөө үзэл баримтлалын шалгuur болоусруулан судалж байна (М. В. Антропова, М. М. Кольцова 1993).

Нэг хэсэг судлаачид (Х. Остер 1963, Ч. Роче, Ж. Ритзел 1968) сургах насыг зөв тогтооход зөвхөн бие эрхтэний хөгжлийг (ялангуяа шудлэлт, ясжилт) судлахад хангалттай гэж үздэг.

Нэгээ хэсэг нь (Л. Винтер 1972 ба бусад) хүүхдийн оюуны чадварыг судлахад хангалттай гэдэг.

Зарим судлаач (И. Гутке 1965) бие хүний төлөвшилтийг хангасан байдлаар нь авч судалдаг.

Хеллевранд М. И. Хелзер Х. (1960) нар сургуулийн зүгээс тавигдах бүхий л шаардлагыг хүүхэд хангаж чадахуйц байх ёстой гэж үздэг.

М. Аббадин болон бусад (1965) судлаачид «сургуульд суралцахад бэлэн болж амжаагүй хүүхэд нь» сонсгал, харааны эрхтэн, уг ярианы яльгүй өөрчлөлттэй байдаг гэж тайлбарладаг.

С. Сзумен (1962) хүүхдийн бие махбод, оюун ухааны хөгжлийн төвшинг орчин тойрны байдалтай (социаль) холбон авч үздэг.

Бид, судлаач С. Сзумений үзлийг барьж, монгол орны өнөөгийн нөхцөлд б насыг сургуульд сургах эхлэх нас гэж үзэн, батлахын тулд насанд нь то-

хирсон сургах арга (тоглоомын), сургалтын шинэ хөтөлбөр боловсруулан хот хөдөөгийн 4 цэцэрлэгт сургах-туршилт явуулж, хүүхдийн хөгжлийн төвшинг сургалт эхлэхийн өмнө, сургалтын дараа үзэж ердийн сургалттай цэцэрлэгтэй харьцуулан 2 жилийн туршид судаллаа.

Судалгааны зарим үр дүнг товч танилцуулбал:

Судалгааны эхний жил буюу 1990/91 оны хичээлийн жилд:

Туршилтын 4 цэцэрлэгийн 6 настай 113 хүүхэд

Хяналтын 4 цэцэрлэгийн 6 настай 113 хүүхэд

Дөрвөн сургуулийн I ангийн 7 настай 113 хүүхэд бүгд 339 хүүхэд, судалгааны хоёрдох жил буюу 1991—92 оны хичээлийн жилд:

туршилтын цэцэрлэгийн 6 настай 102 хүүхэд
хяналтын цэцэрлэгийн 54 бүгд 156 хүүхэд хамрагдсан (Хоёрдох жилийн сургах-туршилтанд хөдөөгийн цэцэрлэгт 6 настай хүүхдийн тоо цөөрсөн).

Бид судалгаанд авсан хүүхдийн тоогоо судлаач Н. Т. Терехова нарын 1975 онд хийсэн сургах-туршилтанд хамрагдсан хүүхдийн тоо, 1976 онд судлаач Т. Ю. Вишнеевскаягийн хийсэн судалгааны тоотой харьцуулан үзэж хамрагдаж байгаа хүүхдийн тоогоо хангалттай гэж үзсэн.

Сургах-туршилтанд хамрагдсан 6 настай нийт хүүхдийн «сургуульд сурахад бэлэн болсон эсэх»-ийг бие бялдарын хөгжилт, эрүүл мэнд, оюуны

Хүснэгт 1.

Н. Т. Терехова нар (1975)	Т. Ю. Вишиевская (1976)	Д. Энхтуяа (1992)
(6 нас)	I жилд 275 (6–7 нас) II жилд 130 (7–8 нас) III жилд 61 (8–9)	I жилд 339 (5,8–7н) II жилд 156 (5,8–6,7)

хөгжлийн зарим үзүүлэлт (сэтгэц-физиологийн талаас)-ийг орчин ахуйн байдалтай нь холбон судалсан юм. Үүнд:

а) Хүүхдийн бие бялдарын өсөлтийг 5 үзүүлэлтээр (биений өндөр, жин, толгой ба цээжний тойрог, Филиппины индекс) антропометрийн аргаар,

б) Эрүүл мэндийг хүүхэд бүрт судлагааны карт хөтлөн, эрхтэн тогтолцооны өвөрмөц үйл ажиллагааг (амьсгалын тоо, зүрхний цохилт, судасны лугшилт, цусны даралт баруун зүүн) үзэж бусад эрхтэнг чагнах, тогших, дарах, тэмтрэх зэрэг аргаар эмчийн үзлэг хийж, нарийн мэргэжлийн эмч нарын

үзлэгийг жилд 2 удаа хийлгэж үзлээ.

в) Хүүхдийн оюуны хөгжлийн зарим үзүүлэлт, өнгө ялгарах чадварыг Е. Б. Рабкины таблицаар, харж дуурайж зурах чадвар, уг хэллэг, багшийн зүгээс өгсөн даалгаврыг гүйцэтгэх чадвар зэргийг Керна-Ирасекагийн тестээр, утга зүйн холбоог ойлгох чадварыг нэг бүрчлэн зураг дээр яриулах аргаар тус тус судалсан.

Энэ удаад бид товч танилцуулах үүдиээс хүүхдийн бие бялдарын өсөлтийг өндөрөөр, эрүүл мэндийг эрүүл хүүхдийн эзлэх хувиар, оюуны хөгжлийн үзүүлэлтийг Керна-Ирасекийн тестээр төлөөлүүлж байна.

Зураглал 1.


**СУРГАХ-ТУРШИЛТЫН 2 ЖИЛИЙН ХУГАЦААНД
6 НАСТАЙ ХҮҮХДИЙН ЖИЛИЙН ДУНДАЖ ӨНДРИЙН
ОСӨЛТ**

ДИАЛАГЧИНЫН ХАМГИНЧУУРЧ АО


ДИАЛАГЧЫН ДАСХУУРЧ ИНДХҮҮХ НАДАН О

ДАНААВ НОЙОН НЕДЕЛЯ

СМ ♂ эрэгтэй




СМ ЧЭМЭГТЭЙ




■ 1990 - 1991 оны хичээлийн жил
■ 1991 - 1992 оны хичээлийн жил

Зураглал 3.
СУРГАХ-ТУРШИЛТЫН 2 ЖИЛИЙН ХУГАЦААНД
6 НАСТАЙ ХҮҮХДИЙН СУРГУУЛЬД СУРАЛЦАХАД
БЭЛЭН БОЛСОН БАИДАЛ

хувь. Хяналтын бүлгийн 6 настай хүүхдүүд.



Түшшилтийн бүлгийн 6-настай хүүхдүүд.



ДҮГНЭЛТ

1. Сургах-түршилтанд хамрагдсан 6 настай хүүхдийн бие-бялдарын хөгжил нь монгол орны байгалийн янз бүрийн бус-нутагт аж төрж байгаа 5 нас 8 сараас 6 нас 7 сартай хүүхдийн ондрийн дундач (Га. Цэрэндорж 1990), Д. Энхтуяа (1992)-тай тохирч байна.

Жилийн дундач өсөлтийн хэмжээ нь судалгааны эхний жилийнхээс дараа жилийнх нь буурч байгаа нь тус орны эдийн засгийн хямрал (хүүхдэд өгөгдөж байгаа хоолны илчлэг буурсан)-тай холбон үзэж байна.

2. Туршилтын 2 жилд Лүн, 107-р цэцэрлэгт эрүүл хүүхдийн эзлэх хувь буурсан нь дээрхи шалтгаанаас гадна өмнөх булгээс ирсэн хүүхдийг зуны улиралд чийрэгжүүлэх, эрүүлжүүлэх ажил хангалтгүй хийж байгаатай холбоотой. Энэ нь хичээлийн жилийн (сургалтын) туршид өсөөд дараагийн сургалт эхлэхэд эрүүл хүүхдийн эзлэх хувь буурч байгаагаар тайлбарлагдана.

3. Бидний Керна-Ирасекийн тест-ээр хийсэн судалгаагаар цэцэрлэгийн нөхцөлд 6 настай хүүхдийн сургуульд суралцахад бэлэн болсон байдал нь: (нийт хүүхдийн)

Сургалтын өмнө	Сургалтын дараа
Улаанбаатарын 107-р цэцэрлэгт	56,7 %
39-р цэцэрлэгт	81,2 %
Төв аймгийн Лүн сумын цэцэрлэгт	33,3 %
Дорноговийн Даланжаргалангийн цэцэрлэгт	14,3 %
боловсруулж бэлэн болсон болно.	92,3 %
	89 %
	86,4 %
	74,5 %

Энэ нь сайн багш, хөгжүүлэх сургалтын үр дүнгэж үзэж байна.

Сургуульд сурахад бэлэн болж амжаагүй байгаа хүүхэд нь олон шалтгаанаас болж болдог: — хүүхэд эхийн хэвлийд байх үеэс 6 нас хүртэл өсөлт торнилт ямар байсан, хэдэн удаа өвчилсөн,

— гэр орны ахуй амьдрал ямар болох, эцэг эхийн боловсрол соёлын төвшин, хоорондын харилцааны ссёл,

— хүүхдийн танин мэдэх үйл ажиллагаанд эцэг эхийн нэлөө,

— цэцэрлэг, орчин тойрны эрүүл ахуйн нөхцөл, дэглэм.

— сургаж байгаа багшийн ур чадвар зэрэг дотоод, гадаад олон нэлөөл, хүчин зүйлээс хамааралтай гэж үзэж байна.

1—3 НАСТАЙ ХҮҮХДИЙН БИЕ БЯЛДРЫН ХӨГЖЛИЙН ХЭВИЙН ХЭМЖЭЭ

Ш. ОРОСОО (Эх нялхсын эрдэм шинжилгээний төв)

1990 оны 9-р сарын 30-нд Нью-Йорк хотноо болсон олон улсын дээд хэмжээний уулзалаас гаргасан «Хүүхдийн эсэн мэнд бойжих нөхцлийг хангах, хамгаалах, хөгжүүлэх тухай дэлхий дахини тухагаллад»: Бүх улс орсон 1990-ээд оны сүүличээр хүүхдийн есөлт хөгжлийг бүрэн хянаадаг албатай болок тухай засан билээ.

Хүүхдийн бие бялдрын хөгжил нь тэдний биеийн галбир, төрх, бүтэц үйл ажиллагааны нэгдмэл илрэл болох жин, өндөр, оргөний хэмжээгээр илэрхийлэгддэг. Энэ нь эрүүл мэндийн нэй чухал шалгуур болдгоороо эмнэлэг урьдчилан сэргийлэх байгууллагын ажилд онол практикийн их ач холбогдолтой (5).

Аль ч улс орны нийгэм, эдийн засгийн хөгжил ард түмний аж амьдралын түвшин ээргийг дагалдан хүүхдийн ялангуяа бага насын хүүхдийн есөлт хөгжил өөрчлөгддог зүй тогтолцой. Сүүлийн 15 жилийн манай улсад бага насын хүүхдийн бие бялдрын хөгжлийн хэмжээн ийлээд өөрчлөгдсөн нь эмноо судалгаагаар тогтоогоғдсон узуулэлтийг (Д. Батчулуун, 1976) өнөөдөр амьдрал практикт хэрэглэхэд тэдий л нийцэхгүй болсныг бидний судалгааны дүү ирголж байна.

Судалгааны зорилго, арга:

1—3 насын эрүүл хүүхдийн бие бялдрын хөгжлийн үндсэн узуулэлтийн хэвийн хэмжээт шинээр тогтоох зорилгоор иштээр хэрэглэж буй сонгомол аргаар (4) Улаанбаатар хотын 1—3 насын 1625 эрүүл хүүхдийн дунд явуулж, статистик боловсруулалтыг варианы аргаар хийв.

Судалгааны ажлын үр дүн:

Судалгаанаас гарсан үр дүн биеийн өндөр, жин, цээж ба толгойн бүслүүр хэмжээ гэсэн 4 үндсэн узуулэлтээр нас, хүйсийн бүлэглэлээр антилан хүснэгт 1а, б-д толилуулав.

З хуртлэх насын хүүхдийн бие бялдрын үндсэн узуулэлтийн улирал тутмын нэмэгдэх дундаж хэмжээг тогтоохын тулд эрүүл иштэй (3), 1 настай эрүүл хүүхдийн (2) бие бялдрын

үндсэн узуулэлтийн хэвийн хэмжээг ашиглав.

Биеийн өндөр,

1 нас 3 сартайдаа эрэгтэй хүүхэд $78,24 \pm 0,27$ см, эмэгтэй хүүхэд $77,66 \pm 0,28$ см өндөртэй байна. 1 нааснаас 1 нас 6 сар хуртлэх хугацаанд эрэгтэй хүүхдийн өндөр нь $7,05$ см, эмэгтэй хүүхдийн $6,63$ см-ээр нэмэгдэж бэйгээ нь 1—3 хуртлэх нийт есөлтийн 40% ; 39% -тай тэнцэж байв.

1 нас 7 сартайгаас эхлэн хүүхдийн есөлт аажмаар саарч 2 хуртэл насын эрэгтэй хүүхэд $2,73$ см, эмэгтэй хүүхэд $2,88$ см-ээр есжээ.

Эрэгтэй хүүхэд 1—2 насын хооронд бундуулаар $9,78$ см, эмэгтэй хүүхэд $9,5$ /см. 2 нааснаас эхлэн есөлтийн хурд дахин саарч 3 нас хүрэх хугацаанд есөлт эрэгтэй хүүхдийн $3,7$ см, эмэгтэй хүүхдийн $2,94$ см байв.

2 бэлтгэж 3 настай хүүхдийн есөлтийг иштэй нь (иштэй уртыг 100% -д) харьцуулбал эрэгтэй хүүхдийн $161,3\%$ ба $176,4\%$, эмэгтэй хүүхдийн $162,5\%$ ба $177,5\%$ -тай тэнцэхээр иштэй байв.

Биеийн жин:

Хүснэгтээс (хүс. 1а, б) хараад 1 нас 3 сартай эрэгтэй хүүхдийн биеийн жин $10,934 \pm 0,077$ кг, эмэгтэй хүүхдийн $10,748 \pm 0,078$ кг байна.

Эрэгтэй хүүхэд биеийн жинигээ 1—1 наас 6 сар хуртээн 1539 г, эмэгтэй хүүхэд 1146 г ёөрөөр хэлбэл улирал тутам дундуулаар 765 г, 673 граммаар нэмсэн байв.

1 нас 6 сараас^{*} 2 настайд эрэгтэй хүүхэд биеийн жинигээ 589 г, эмтэй хүүхэд 817 г нэмж, биеийн жинигийн улирал тутмын нэмэгдэл нь эрэгтэй хүүхдийн 294 г, эмэгтэй хүүхдийн $408,5$ г, ялангуяа эрэгтэй хүүхдийн энэ насын улирлын жинигийн нэмэгдэл мэдэгдэхүйц буурсан байдал ажиглагдав.

2 нааснаас эхлэн хүүхдийн биеийн жин мэдэгдэхүйц ишэвч, эрэгтэй хүү-

1-3 наасны эрэгтэй хүүхдийн бие бэлдрийн сэсelt хөгжлийн хэвийн хэмжээ

Хүснэгт 1

Нас	Биесийн ондөр (см)			Биесийн жин (кг)			Цээжний буслуулж хэмжээ (см)			Толгойн буслуулж хэмжээ (см)			
	n	M	±m	±σ	M	±m	±σ	M	±m	±σ	M	±m	±σ
1 нас 3 сар	107	76,24	2,72	0,27	40,934	0,077	0,78	40,25	0,15	1,51	48,30	0,10	1,10
1 нас 6 сар	100	81,76	0,31	0,33	41,708	0,056	0,86	50,79	0,17	1,70	48,81	0,10	1,05
1 нас 9 сар	105	82,73	0,21	0,21	42,018	0,053	0,85	51,01	0,13	1,37	49,16	0,10	1,07
2 нас	100	83,89	0,31	0,31	42,537	0,062	0,82	51,35	0,15	1,59	49,32	0,10	1,05
2 нас 3 сар	110	85,55	0,33	0,33	42,814	0,051	1,03	51,93	0,18	1,81	49,59	0,10	1,03
2 нас 6 сар	106	88,96	0,28	0,28	43,261	0,107	1,04	52,77	0,18	1,86	49,99	0,10	1,08
2 нас 9 сар	100	90,14	0,31	0,31	43,744	0,052	0,922	53,02	0,16	1,16	50,24	0,03	0,96
3 нас	103	91,76	0,36	0,36	44,318	0,101	1,033	53,79	0,15	1,61	50,59	0,11	1,15

1-3 наасны эмэгтэй хүүхдийн бие бэлдрийн сэсelt хөгжлийн хэвийн хэмжээ

Хүснэгт 1

Нас	Биесийн ондөр (см)			Биесийн жин (кг)			Цээжний буслуулж хэмжээ (см)			Толгойн буслуулж хэмжээ (см)			
	n	M	±m	±σ	M	±m	±σ	M	±m	±σ	M	±m	±σ
1 нас 3 сар	95	77,66	0,26	2,56	10,748	0,078	0,76	49,11	0,15	1,53	47,67	0,10	1,01
1 нас 6 сар	97	80,08	0,25	2,46	11,178	0,066	0,63	49,83	0,15	1,57	47,88	0,03	0,88
1 нас 9 сар	97	81,48	0,24	2,45	11,581	0,061	0,79	50,21	0,14	1,45	48,10	0,03	0,46
2 нас	95	82,96	0,55	2,47	11,995	0,079	0,77	50,49	0,16	1,56	48,55	0,10	1,04
2 нас 3 сар	98	84,73	0,28	2,3	12,53	0,090	0,81	51,18	0,15	1,55	48,90	0,11	1,11
2 нас 6 сар	100	87,59	0,31	3,19	13,771	0,090	0,90	52,0	0,17	1,74	49,29	0,11	1,11
2 нас 9 сар	105	89,54	0,31	3,20	13,599	0,103	1,05	52,36	0,18	1,89	49,37	0,23	2,36
3 нас	107	90,53	0,33	3,48	13,890	0,099	1,03	52,67	0,16	1,67	49,66	0,10	1,09

хэд улирал тутам дунджаар 512 г эмэгтэй хүүхэд 588 г, 2 нас 6 сараас 3 настайд эрэгтэй хүүхэд улирал тутам 478,6 г, эмэгтэй хүүхэд 359,5 г нэмсэн.

1-ээс 3 нас хүртэл эрэгтэй хүүхэд биесийн жингээ 4100 г, эмэгтэй хүүхэд 3858 г нэмж, 3 настай эрэгтэй хүүхэд дунджаар $14,318 \pm 0,101$ кг, эмэгтэй хүүхэд $13,890 \pm 0,099$ кг жинтэй болж байв.

Цээжний бүслүүр хэмжээ:

1 нас 3 сартайдаа эрэгтэй хүүхдийн цээжний бүслүүр хэмжээ $49,25 \pm 0,15$ см, эмэгтэй хүүхдийнх $49,19 \pm 0,15$ см байна. 1—1 нас 6 сартайд эрэгтэй, эмэгтэй хүүхдийн цээжний бүслүүр хэмжээ улирал тутамд дунджаар $1,34$ см нэмэгдэж байхад 1 нас 6 сараас 2 настайд эрэгтэй хүүхдийнх $0,56$ см, эмэгтэй хүүхдийнх $0,66$ см-эр нэмэгдэн 2 настай эрэгтэй хүүхдийн цээжний бүслүүрийн дундаж хэвийн хэмжээ $51,34 \pm 0,15$ см, эмэгтэй хүүхдийнх $50,49 \pm 0,16$ см болсон байв.

2—2 нас 6 сартайд эрэгтэй хүүхдийн цээжний бүслүүр хэмжээ улирал тутамд $0,71$ см, эмэгтэй хүүхдэд $0,75$ см нэмэгдэж 2 нас 6 сартайд эрэгтэй хүүхдийн цээжний бүслүүр хэмжээ $52,77 \pm 0,18$ см, эмэгтэй хүүхдийнх $52,0 \pm 0,17$ см-тэй тэнцэж байна.

2 нас 6 сараас 3 настайд улирал тутамд эрэгтэй хүүхдийн цээжний бүслүүр хэмжээ дунджаар $0,51$ см, эмэгтэй хүүхдийн $0,33$ см нэмэгдэж, 3 нас хүрээдэд эрэгтэй хүүхдийнх $53,79 \pm 0,15$ см, эмэгтэй хүүхдийнх $52,67 \pm 0,16$ см болжээ.

1—3 насны хооронд эрэгтэй хүүхдийн цээжний бүслүүр хэмжээ $5,69$ см, эмэгтэй хүүхдийнх $5,53$ см-эр тус тус нэмэгдсэн нь ажиглагдав.

Толгойн бүслүүр хэсжээ:

Хүснэгтээс (хүс. 1а, б) харахад 1 нас 3 сартай эрэгтэй хүүхдийнх $48,30 \pm 0,10$ см, эмэгтэй хүүхдийнх $47,67 \pm 0,10$ см байна.

Эрэгтэй хүүхдийн толгойн бүслүүр хэмжээ 1—2 настайд $2,07$ см, эмэгтэй хүүхдийнх $2,16$ см-эр нэмэгдэж байна.

Харин 2—3 настайд эрэгтэй хүүхдийнх $1,27$ см, эмэгтэй хүүхдийнх $1,11$ см-эр нэмэгдэж 3 нас хүрээд

эрэгтэй хүүхдийн толгойн бүслүүр хэмжээ $50,59 \pm 0,11$ см, эмэгтэй хүүхдийнх $49,66 \pm 0,10$ см болж байв.

Бид судалгааныхаа узүүлэлтийг 15 жилийн өмнөх (1) узүүлэлттэй харьцуулан уззхэд эрэгтэй хүүхэд биесийн жин, өндөр, толгой ба цээжний бүслүүр хэмжээгээр илүү байгаа нь тооны үнэн магадлалтай ($P < 0,001$) батлагдаж байна. 3 настай эмэгтэй хүүхдийн биесийн жин, толгойн бүслүүр хэмжээ тоон узүүлэлтээрээ харьцангуй илүү байгаа боловч тооны үнэн магадтай ($P > 0,005$, биш байна).

Харин бусад бүх насандaa эмэгтэй хүүхэд биесийн жин, өндөр ба толгой цээжний бүслүүр хэмжээгээрээ 15 жилийн өмнөх чацуутнаасаа тооны үнэн магадтайгаар илүү байгаа нь итогодсөв ($P < 0,001$).

2 ба 3 нас хүрээдэд эрэгтэй хүүхэд биесийн өндөрөө нярай уеэсээ $1,61 : 1,76$ дахин, эмэгтэй хүүхэд $1,62 : 1,77$ дахин, биесийн жингээ аль ч хүйсэнд $3,58$ дахин, эрэгтэй хүүхдийн цээжний тойргийн хэмжээ $1,51 : 1,59$ дахин, эмэгтэй хүүхдийнх $1,49 : 1,55$ дахин, эмэгтэй хүүхдийн толгойн тойргийн хэмжээ $1,39 : 1,43$ дахин, эмэгтэй хүүхдийнх $1,37 : 1,40$ дахин өсчээ.

ДҮГНЭЛТ

1. 1—3 насандaa хүүхдийн өндөр дунджаар хүү ба охинд $17,65$ см : $17,08$ см; биесийн жин 4100 г, 3858 г; цээжний бүслүүр хэмжээ $5,69$ см, $5,53$ см; толгойн бүслүүр хэмжээ $3,34$ см, $3,27$ тусл тус нэмэгдэх зүй тогтол илрэв.

2. Бидний судалгаа гар тогтоогдсон бага насны хүүхдийн бие бялдрын өсөлт хөгжилтэй 15 жилийн өмнөх хүүхдийн бие бялдрын өсөлт хөгжилтэй илүү хурдаатай явагдаж байгаа нь орчин үеийн нийгэм-эдийн засаг, соёл иргэншил гэх мэт олон болгарийн нөлөөгөөр өнөөгийн Улаанбаатарын хүн амын харьцангуй эруул энх аж төрж байгааг нотолж байна.

3. Дээрхү бага насны эрүүл хүүхдийн бие махбодийн хэвийн узүүлэлтийг эмнэлэгт урьдчилсан сэргийлэх болон хүүхдийн бусад байгууллагад эрүүл ба өвчтэй хүүхдийн эрүүл мэндийн байдалд дүгнэлт. өгч, хянахдаа харьцуулал, ишлэл татан ашиглаж болно.

4. Нэг нас 6 сартайгаас 2 насны хооронд хүүхдийн бие бялдрын өсөлт

хөгжлийн эрч саарч байгаа нь энэ үеийн онцлог байж болох боловч хүүхдийн бие махбодид язь бүрийн болит шаардлага нэмэгдэж буйт илтгэн харуулж байна.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

1. Д. Батчулуун «Физическое развитие детей от 1-ого месяца до 17 лет и некоторые гигиенические вопросы акселерации развития школьников г. Улан-Батора». Дисс. канд. мед. наук. УБ. 1981.

2. Г. Ороссоб «Физическое и нервно-психическое развитие детей первого

года жизни г. Улан-Батора». Автограф. канд. мед. наук. УБ. 1990. с. 9—10.

3. Г. Навчсан. «Эрүүл нярай хүүхдийн бие бялдар, энзим биохимиин зарим үзүүлэлтүүдийн хэвийн хэмжээ» Аргачилсан зөвлөмж. УБ. 1986.

4. А. Б. Ставицкая, Д. И. Арон. «Методика исследования физического развития и детей подростков» М. Медгиз. 1959.

5. Т. Я. Черток. Г. Нишиб «Состояние здоровья и диспансеризации детей раннего возраста» М. 1987 г. с. 64.

ЭХИЙН СҮҮНИЙ ХАНААГҮЙ ХҮЧЛҮҮДИЙН ХОЁРЧИЙН ХОЛБОО-ТРАНС ИЗОМЕРИ БАЙГУУЛСАН НЬ

Б. СҮХБААТАР (дэд доктор) **С. МАЖИГСҮРЭН** (дэд доктор)
Ц. Намсрай (доцент)

Эхийн сүүний тосны ханаагүй хүчлийн хоёрчийн холбоо ны байршил ба түүний цис транс изомери байгууламжийг судлах явдал нь биологийн чухал ач холбогдолтой болохыг Nestel P. L (АНУ. 1) Harrer Q. Haug. M (Герман. 2) Tadashi Idota, Toshio Sakunai (Япон. 3) болон бусад олон тооны судлаачид тогтоож шинжлэх ухааны таамаглал бүхий асуудал дэвшүүлсэн материалыг бичих болсон байна.

Иймд монгол эхчүүдийн сүүний тосонд агуулагдах ханаагүй хүчлүүдийн хоёрчийн холбооны байршил ба цис транс изомери байгууламжийг судлахын тулд үн хөргөлтийн аргаар ханаагүй тосны хүчлүүдийг бусад тосны хүчлүүдээс салгалт хийх ажлыг хэд дахин давтан хийсний дараа Гильдмичийн аргаар хүчиллэг орчинд ацетоны уусмал байдалд байхад нь перемангнат калиар исэлдүүлэн хоёрчийн холбоо

гоор нь таслаад үссэн дикарbon хүчлүүдийг диятилийн эфирт, монокарбон хүчлүүдийг петролеины эфирт уусган авч хий-шингэний хроматографи (ХШХ) дараах нөхцөлд бичлэг хийж тодорхойлов. Үүнд:

Хроматон «A» силькогель дээр этиленгликольадинатыг шингээсэн сорбентоор цэнэглэсэн 4 м колонко ашиглан устэрөгчийн ионжуулсан дөлт детекторт зөөгч хий гелийн 0,4 л/мин-урсгалд, монокарбон хүчлийг 120°C-д дикарбон хүчлийг 198—200°C-д тус тус тодорхойлоход пеларганы болон азелаины хүчил үссэн байв. Үүнээс үзэхэд ханаагүй хүчлүүд исэлдэхдээ дараах маягийн механизмаар явагджээ гэж үзэв.

Нэгэнт пелерганы ба изелаины хүчил үссэн болохоор олеины хүчлийн ханаагүй холбоо нь 9 ба 10 нуурстөрөгчийн атомууд дээр байна гэж үзэх бүрэн үндэстэй юм.

Линол, Линолеини ба ара-

хидоны хүчлүүдийг исэлдүүлэхэд онол ёсоор нэг молекулаас нэг молекул монокарбон хүчил, хоёр молекул дикарбон хүчил үүсэх бөгөөд хорчийн холбоо нь өөр байрлалд шилжсэн байвал судалгааг амархан будилуулдаг явдлаас зайлсхийхин тулд тухайн хоёр хүчлийг исэлдүүлэхээсээ урьд метилийн эфир үүсгээд дараа нь ихэд дэлгэрсэн арга болох Гарри-молинарийн азонжуулах аргаар озонид үүсгэн цуугийн хүчлийл орчинд цайрын тосны

хүчлийн хувьд пропионы хүчил, малоны хүчил мөн азелеины хүчлийн дутуу эфир үүссэн байв. Энэ хүчлийн задралын бүтээгдэхүүнд хийсэн хроматограммын тооцоог хийхэд линолейлын хүчилтэй адилхан хэмжээтэй дээж авч тодорхойлолт хийхэд линолеины хүчлээс үүссэн малоны хүчил бараг хоёр дахин их байв. Энэ нь Линолеины хүчлийн ханаагүй холбоонууд 9, 12, 15-р нүүрстөрөгчийн атомууд дээр байгааг баталж байна.

ОЛЕЙНЫ ХҮЧИЛ




ЛИНОЛИЙН ХҮЧИЛ



ЛИНОЛЕЙНЫ ХҮЧИЛ



АРАХИДОНЫ ХҮЧИЛ



бролцоотойгоор задалж дээр дурьдсан нөхцөлд (ХШХ)-ийн аргаар тодорхойлоход линолийн хүчлээс капроны хүчил, малоны хүчил, азелайны хүчлийн метилийн дутуу эфир тус тус үүссэн явдал Линолийн хүчлийн ханаагүй холбоо 9 ба 12-р нүүрстөрөгчийн атомууд дээр байгааг ностлов. Линолеины

$C_{17} H_{33} COOH$



$C_{17} H_{31} COOH$




$C_{19} H_{31} COOH$



ханаагүй хүчлүүдийн хувьд транс изомери нь холбооны байрлал тодорхойлох исэлдүүлэх явцад хүчил үүсэхийн оронд хүчлийн ангидрид үүсч будлиантуулдаг явдал цөөнгүй тохиолддог, зөвхөн олеины хүчил л цис-транс хоёр изомеритэй байхад линолын хүчил—8 линолеины хүчил 16, арахиди-

жинчүү, жинчилүү, дайсан шинчилүү
ишигэвчийн тосны ханаагүй нийтийн

ДОЛГИОНЫ УРТ



Зургийн тайлбар: Нил улаан туяаны спектрээр эхийн сүүний тосны ханаагүй хүчлийн цис изомери байгууламжийг тодорхойлсон байдал.

ны хүчил—32 изомеритэй байдаг тул эдгээрээс аль нэг нь байхгүй гэж үзэх үндэсгүй юм. Учир нь транс изомери нь химийн идэвхээр муу батжил сайтай байдгаас гадна цис изомери нь химийн элдэв урвалжууд болон гэрэл, дулааны үйлчлэлт тэсвэр муутай, амархан транс изомерит хувирдаг тул тос гарган авах, тэдгээрийн хүчлүүдийг тодорхойлох явцад изомерүүдийн шилжилт ч болсон байж болох юм гэж үзсэнээс бид холбооны байршил тодорхойлохоосоо өмнө тосноос гарган авч цэвэрлэсэн тосны хүчилдээ хэт улаан гэрлийн шингээлтийн спектр авсан юм. Үүнд:

UR—20 маркийн хэт улаан гэрлийн спектрометрт натри хлорын линзинд нимгэн үеэр авав. Спектрофотометрийн программ нь гэрлийн хүзүүвчлэлийн өргөн 4, Бүртгэлийн хурд 160, бүртгэлийн нарийвчлал 4, ойролцоо өсгөгч 7, нарийвчилсан өсгөгч 5, цаасны хурд 10 байв. Дурьдсан нөхцөлд гарсан спектрограммд транс изомерийн шингээлт өгвөл 970 cm^{-1} долгионы уртад ямар ч шингээлт өгөөгүй бөгөөд харин ханаагүй холбооны цис формын шингээлт өгдөг муж 3020 cm^{-1} -д 3,02—3,69 микрон долгионы уртад нилээд тод зураас өгснийг зурагт харуулав.

ЭЛЭГ ЦӨСНИЙ АРХАГ ЭМГЭГИЙГ ДҮРСЛЭЛ ОНОШЛООНЫ АРГААР ОНОШЛОХ БОЛОМЖ, ХЯЗГААР ЧИГ БАРИМЖАА

П. ОНХУУДАЙ (АУ-ны доктор, Клиникийн I нэгдсэн эмнэлэг)

Элэг судалал хөгжсөөр байна. Элэг судлалын клиник, биологийн «уран барилга», боссоор байна. Гэвч элэгний өвчний онош, эмчилгээний хувьд зарим асуудлыг шийдвэрлэгүй байна. Элэг судлалын мэдлэгийн «шур», «суур»-ыг маш их хөдөлиймөрөөр эрж олон боловч магадгүй түүнээ хаамашигээдээ л төрөлдөж байж болох юм.

Генатологиг элэг, цөсний архаг өвчний эрт илрүүлэн оношлох нь ялмагт шийдвэрлэх асуудлын иег хэвээр байгаа юм. Олон улс оронд түүн дотроос манай оронд элэг, цөсний архаг эмгэг жил бүр нэмэгдэж байна. Ер нь элэгний архаг гепатит нь элэгний өвчин эмчлэгдэх, эмчлэгдэхтүйн зааг юм.

Манай усадад 1961 оноос эпидеми маягаар дэлгэрсэн элэгний халдуварт шар өвчин (А гепатит) болон В гепатитын уршиг, элэгний өвчинүүд архатийн даамжрахын нэг үндсэн шалтгаан болсон бөгөөд бодисын солижлооны зарим өвчинүүд, эрс тэс уур амьсгал, хэрэглэж заниссан хоол ууд, үйздвэрийн хорт хүчин зүйл, архаг архидалт, эмийн бодис хэт хэрэглэлт зөрт нь элэг, цөсний өвчиний архагшийн даамжрахад зохих нөлөө узүүлж байна.

Элэг цөсний архаг эмгэгийг эрт илрүүлэн оношлох боломж, ач холбогдол, чиг баримжааны тухайд орчин үеийн дүрслэл оношлогооны олон аргуудыг хэрэглэх үндэстэй боловч, эрдэмтэд судлаачид өлий хүртэл нэгдсэн иег чиглэлгүй байгаа юм. Энэ нь дүрслэл оношлогооны аргууд болох цемийн онош зүй (изотоп) хэт авинан оношлогоо (эхографи), компьютер томографи, дурант-дүрслэл оношлогооны шинжилгээгээр хүний элэг, цөсний замын эрүүл узүүлэлтийн хувьд олон янз тогтсон хэм хэмжээ (критери) байхгүй байгаатай холбоотой юм.

Бидний ажлын нэг зорилго бол орчин үеийн дүрслэл оношлогооны баガажаар эрүүл хүний элэг, цөсний замын хэм хэмжээг монгол хүн дээр тогтоох, мөн элэг, цөсний архаг өвчний дүрслэл оношлогооны аргаар эрт, нааг тухайд нь оношлох боломж, хязгаар, ач холбогдол, чиглэлийг тодорхойлох асуудал байв.

Материал арга зүй. Бид улсын Клиникийн Төв эмнэлгийг түшиглэн 100 эрүүл хүн, 1805 элэг, цөсний архаг өвчтэй хүмүүсийг шинжилгээндээ сонгож авсан билээ Клиникийн субъектив, объектив шинж тэмдэг, элэгний серологи, иммунологи, эндоскопи, компьютер томографи, элэгний биопси, лапароскопийн туслаамжтайгаар клиник онош батлагдсан хүмүүс байв. Үүнд:

— Эрүүл (хяналтын хэсэг)	100
— архаг холенистит	100
— архаг аажим гепатит	565
— архаг идэвхт гепатит	460
— өөхөнжон элэг	90
— элэгний цирроз	310

Дараа нь дээрх эрүүл ба өвчтэй хүмүүст цемийн онош зүйн шинжилгээнүүд статик сцинтиграфи, үйл ажиллагааны сцинтиграфи, гелатос-цинтиграфи, ультра сонографи, компьютер томографийн шинжилгээ хийж үр дүнг үнэлсэн юм.

1. Статик сцинтиграфи — гамма камер ФО—ЗЛЦ—37— (Сиймэнс фирм, ХБНГУ)-аар радиофармака Тс—99 м хүхэрлэг колloidыг 74 МБК идэвхтэй 0,5—1,0 мл венийн судсаар тарьж шинжилгээг хийв.

2. Үйл ажиллагааны сцинтиграфи — Гамма камераар, радиофермака Тс—99м—ЭХИДА-г 74—185 МБК идэвхтэй, 0,5—1,0 мл-ээр в'инийн судсаар тарьж 32 мин-ийн турш үучилсан сцинтиграммийн зураг авав.

3. Гепатографи — Кадми-Теллур-Детектороор Тс—99—ЭХИДА-г 74—185 БМк идэвхтэй, 0,5—1,0 мл-ээр венийн судсандаа тарьж, уйл ажиллагааны муурийг 60 мин турш тасралтгүй зурав.

4. Ультрасонографи — Эхокамер (Алоха ССД—256,650, Япон) аар элэг, цөсний зам, дэлүүний шинжилгээг хийллээ.

Шинжилгээнд 18—78 насны 1136 (62,9%) эргэгтэй, 669 (37,1%) эмэгтэй хамрагдлаа.

Цөмийн онош зүйн шинжилгээг орчин үеийн оношлогооны өндөр мэдрэмтгийн тоолууртай Гамма камер, хэт авиан сношлогоог компьютертэй универсаль эхокамераар хийсэн бөгөөд өөрсдийн зохион бүтээж шинэ бүтээлийн гэрчилгээ авсан хагас дамжууллагч Кадмителлурид тоолуурыг ашигласан юм.

Шинжилгээний үр дүнгийн үнэн зөвийг клиник шинжилгээний аргууд болон өвчийн клиник явцаар шалгасан билээ.

ҮР ДҮН

1. Эрүүл элэг

а) Статик сцинтиграфийн аргаар элэг эрүүл 100 хүний шинжлэхэд хэв шинжит гурвалжин дурсаас гадна (35%) гадна бөөрөнхий дөрвөлжиндүү, зүүн баруун дэлбэн хэвийн байдал том, бага байх г. м. 13-ийн дурс илрэв. Элэгний дүр төрх янз бүр байдгаас түүний (контур) зах ирмэгийн хэлбэр өөр өөр, мөн гаднаас тэмтрэгдэх байдал ч харилцан адилгүй байв. Бидхэвлэл номд бичигдсэн статик сцинтиграмм дээр илрэх элэгний дүр төрхөөс гурван шинэ хэлбэрийг олсон юм. Элэгний дүр, төрхийг тухайн хүний биеийн төрөлх галбиртай холбож үзэх нь зүйтэй юм. Элэгний зүүн дэлбэнгийн дурслэл олон янз дүр төрхтэйгээс гадна зарим тохиолдолд жижиг дурслэгдэг нь оношлогоонд бэрхшээл учруулах боломжтой. Харин баруун дэлбэн (32%) доош уртсан нарийсах (Рийдэлийн дэлбэн) онцлог байв.

Монгол хүний элэгний дүр төрхийг голдуу европын судлаачдын үзүүлэлттэй (41%) харьцуулбал хэв шинжит гурвалжин дүр харьцангуй бага хувь эзлэх учраас бусад хэв шинжит бус дүр төрхүүд нь илүү олон хувилбартаар байгаа нь нотлогдов.

б) Уйл ажиллагааны сцинтиграфиаар эрүүл элэгийг шинжилж хэвийн дундаж үзүүлэлтийг тодорхойлов.

	(М±) мин
Элэгний цуллаг дахь Т макс	13,00±0,9
T 1/2	31,40±0,2
Элэгний дурслэл	гурвалжиндүү
	ижил
	терөлшилтэй
Цөсний ерөнхий цоргын дурслэл	14,43±1,7
Цөсний гэр дурслэгдэж эхлэх	16,06±1,8
Цөсний гэрийн бүрэн дурслэл	18,28±2,4
Өлөн үед 32 мин-д дээд гэдэс дурслэгдэх байдал	бага зэрэг

Үйл ажиллагааны сцинтиграфи нь элэгний дүр төрх түүний цуллагийн цусан хангамж, элэгний шимэх, ялгаруулах үйл ажиллагаа цөсний цоргын болон цөсний гэрийн дурслэлийг үзүүлэхэд чухал ач холбогдолтой, бүтэц-үйл ажиллагааны шинжилгээ юм.

б) Эрүүл элэгний гепатограммын үзүүлэлт

Хэвийн утга (насанд хүрэгчдэд)

	(мин)
Хамгийн их идэвхижлийн эхлэх хугацаа	23,68±1,2
Хамгийн их идэвхижлийн дуусах хугацаа	46,2±2,4
Муурийн тэгшиж хугацаа	24,24±1,7
Элэгний ялгах хагас хугацаа	8,90±1,6
Дээд гэдэсэнд идэвхжил очих хугацаа	26,79±2,1

Гепотографи нь элэгний үйл ажиллагааг шалгахад мэдрэмтгий энгийн шинжилгээ юм.

г) Эрүүл элэг, цөсний зам, дэлүү, судасны ультрасонограммын үзүүлэлт.

Элэг

Хэмжээ, зах ирмэг, хэт авийн бүтэц

Баруун дэлбэн (эгэмний дунд шугамаар) $11,92 \pm 2,1$ см

Зүүн дэлбэн (дунд шугамаар) $5,43 \pm 2,6$ см

Урд ирмэг Бага зэрэг гүдгэр, полгөр

Хойт ирмэг, элэгний «өнцөг» Хотгор хурц

Хий хязгаар тодорхой

Ойлтын хэмжээ (цуурайн эрчимжил) жижгээс дунд зэрэг

Ижил төрөлшил харьцангуй жигд

Ойлтын тархалт нэг жигд

Ойлтын нягт нягт бус

Элгэн доторхи цөсний цорго ойлтын цайвар тууз

Цөсний ерөнхий цорго $3,33 \pm 0,2$ мм

Элэгний вен $5,28 \pm 1,0$ мм

Хаалган вен $8,67 \pm 0,7$ мм

Доод хөндий вен $9,26 \pm 1,2$ см

Цөсний гэр $8,31 \pm 1,0 \times 3,68 \pm 0,6$ см

Хэмжээ голдуу зууван

Хэлбэр ойлтын нарийн тууз

Хана хүзүүвч жигд

Цөс, доод бүтэц Дэлүү

Хэмжээ $8,90 \pm 1,7 \times 4,48 \pm 0,2$ см

Цуурайн бүтэц нягт бус

Дэлүүний вен $4,65 \pm 1,2$ мм

Эргэн тойрны хэмжээ $23,17 \pm 2,3$ см

Хөндлөн огтлол $27,13 \pm 2,5$ см²

Үнелэлт: Эрүүл элэгний бүтэц үйл ажиллагааг үнэлэхэд ультрасонографи нь энгийн хурдан, түяаны ачаалалгүй, хямд төсрөөрөө бусад шинжилгээнээс давуу юм.

2. Цөсний гөрийн архаг үрэвсэл. Цөсний гөрийн архаг үрэвслийн оношлогоонд статик сцинтиграфи болон гепотографийн шинжилгээний ач холбогдол бага юм. Харин үйл ажиллагааны сцинтиграфийн хувьд цөсний гэр, цөсний замын үйл ажиллагааг цаг хугацааны дургаар үнэлэхэд чухал шинжилгээ юм. Архаг холециститийн уед ихэнх тохиолдолд радиофармака дээд гэдсэнд хэвийн хугацаанаас өмнө очдог нь илэрсэн бөгөөд энэ нь цөсний гэр дурселгэдэхгүй шалтгаан болж байна.

Ультрасонографийн шинжилгээгээр архаг холециститийн уед өөрчлөгдсөн цөсний гөрийг (томорсон, жижгээрсан, хатуурсан, хорчийсон, хана нь зузаарсан, чуулутай, хийтэй тэх мэт) амархан оношлох боломжтой юм. Цөсний гэр 87% хэлбэр өөрчлөгдсөн, 68% томорсон, 21,5% жижгээрсан. Цөсний гөрийн хана ямарг зузаарсан, хатуурсан, зарим тохиолдолд шохойжон «яжсан» (21%) байв, 2 тохиолдолд цөсний гөрийг дурсэлж чадаагүй байна. Зөвхөн 13% хэвийн хэлбэр төрх, хэмжээтэй цөсний гэр тодорхойлогдсон.

Үйл ажиллагааны сцинтиграфийн үзүүлэлт:

Элэгний цуллаг дахь Tmax $14,45 \pm 0,6$ мин

T1/2 $33,72 \pm 1,2$ мин

Элэгний доторхи цөсний цоргын дурселэл $15,20 \pm 1,1$ мин

Элэгний дурселэл

Гурвалжин, ижил төрөлшилтэй.

3°

Цэсний тэрэлшилтэй, харин
Цэсний гэр дүрслэгдэх эхлэх 20,50±2,3 мин
Цэсний гэрийн бүрэн дүрслэл 23,31±2,1 мин
Өлөн уед 32 мин-д дээд гэдэс
дүрслэгдэх байдал язж бүр

Цэсний гэрийн дотор бутцийн хувьд 46% ижил тэрэлшилтэй, харин 32%-д ижил тэрэлшил алдагдсан ойт ихэссэн байв. Цэсний гэрийн ханын дотор талд 46% гөлгөр тэгш 32% ямар нэг хэмжээгээр ич багаар гөлгөр тэгш байдал алдагджээ. 32% буюу 128 өвчтөнд цэсний чулуу 44 өвчтөнд цэсний гэрт хий олдсон ба 57 тохиолдолд цэсний гэрийн ёроолд цэсний өтөн тунамал дүрслэгдэв:

Үзэлэлт: Архаг холециститийг эрт оноочтой зөв оношлоход ультрасонографи, үйл ажиллагааны сцинтиграфи зайлшигүй шаардлагатай.

3. Архаг гепатит

Статик сцинтиграфи: Элэгний архаг аажим болон идэвхит гепатитын үед голдуу эзэгний баруун, зүүн дэлбэн болон дэлүү хэвийнээс томорч дүрслэгдсэн байв. Элэгний идэвхит гепатитын үед дэлүү 82% тодорхой томорсон байв. Элэгний зураглалын хэвийн ирмэг шулуусан байдал. Элэгний статик сцинтиграммаар элэгний архаг аажим ба идэвхит гепатитыг ялгах оношлоюх боломжгүй юм. Харин үйл ажиллагааны сцинтиграфи, гепатографи нь элэгний архаг, аажим идэвхит гепатитыг ялгах оношлоход чухал ашигтай болохыг шинжилгээний үр дүн харуулж байна.

а) Үйл ажиллагааны сцинтиграфийн үзүүлэлт:

	архаг аажим	архаг идэвхит гепатит (мин)	архаг идэвхит гепатит (мин)
Элэгний цуллааг дахь Тмакс	15,44±1,4	19,82±1,3	
T _{1/2}	33,19±1,2	39,78±2,2	
Элэгний дүрслэл	голдуу гурвалжиндуу, томорч	хэлбэр өөрчлөгдсөн, нэвчлийт	
Элгэн доторхи цэсний цөргүүн дүрслэл	16,44±1,7	25,69±1,6	
Цэсний гэр дүрслэгдэх эхлэх	17,74±2,1	25,69±1,6	
Цэсний гэрийн бүрэн дүрслэл	25,93±1,7	28,67±1,8	
Өлөн уед 32 мин-д дээд гэдэс	тод дүрслэгдэнэ. Идэвхийн эрчимийн дүрслэгдэх байдал		
	жил нь элэгнийхээс бага		

Элэгний архаг өвчтүүдийн хооронд нь ялгахад Тмакс T_{1/2} болон элэгний дүрслэл чухал юм.

б) Гепатографийн үзүүлэлт:

	Архаг гепатит	Архаг гепатит
аажим (мин)	идэвхит	идэвхит
t ₁	32,53±1,8	34,65±1,2
t ₂	56,90±1,1	59,91±0,8
t ₃	33,47±1,4	42,49±1,7
t ₄	12,38±1,1	16,00±0,6
t ₅	42,20±2,5	54,83±2,2

Гепатографи нь архаг аажим идэвхит гепатитыг ялган оношлоход мэдрэмжтийг шинжилгээний арга юм.

Ультрасонографийн үзүүлэлт:

Элэгний аажим гепатит Элэгний баруун, (13,60±1,4 см) зүүн (9,37±1,2 см) дэлбэн томорсон. Элэгний урд ирмэг гөлгөр шулуун ар крмэг гөлгөр, элэгний онглог ихэсжээ. Элэгний ойр орчмын эрхтэнтэй хиллэх хязгаар тод харагдах бөгөөд элэгний бүрхүүл тодорхой хэмжээгээр зузаарчээ.

Элэгний цуурай-бутэц: Ойлтын хэмжээ-лунд зэрэг, эрчимтэй ойлтын тархалт жижд, ойлтын нягт ихэссэн, түгээмэл, ижил тэрэлшилд хадга-

лагдсан, элгэн дэх хэт авиан сулрал ихэссэн. Дэлүү тодорхой хэмжээгээр томорсон, цуурай-бүтэц жигд, бага зэрэг эрчимтэй.

Элэгний идэвхит-гепатит: Элэг томорсон. Ихэнх тохиолдолд элэгний зүүн дэлбэн илүү томорсон, элэгний онцөг мөлийсэн.

Цуурай бүтэц: Ойлтын хэмжээ дунд зэргэс будуун, эрчимтэй. Ойлтын тархалт голдуу жигд бус, ойлтын нягт илэрхий ихэссэн нэвчимтгий байдалтай. Ижил төрөлшил алдагдаж эхэлсэн. Элгэн дэх хэт авиан сулрал илэрхий ихсэж, эх-эрчимжил нэвчимтгий байдлаар мөн ихэссжээ. Дэлүү өвчний явц ус шатаас шалтгаалан томролт нь нэмэгдэж байдаг. Энэ нь дэлүү ямагт томорсон байх бөгөөд дэлүүний цуурай бүтэц: жигд, эрчимтэй, байдлаар илэрхийлэгдэнэ. Архаг идэвхит гепатит широз руу шилжих үед ультрасонографийн хэмжээнүүд улам тодорхой болж бөөрч лөгдэж ирээ.

Үнэлэлт: Архаг гепатитыг эрт цаг тухайд нь оноөвчтой зөв оношлоход үйл ажиллагааны сцинтиграфи, гепатографи бусад дүрслэх оношлогооны аргаас илүү мэдрээгийг гэж үзнэ.

4. Шөхөжөн элэг. Үйл ажиллагааны сцинтиграфи, гепатографийн шинжилгээний чийгээ нь бага юм. Харин статик сцинтиграфийн үед өөхжэсэн элэгийн баруун зүүн дэлбэн ямагт томорсон байдаг. Ультрасонографийн шинжилгээ: Элэг томорсон. Ойлтын нягт ямагт илэрхий ихэссэн. Ганцаарчилсан цуурайн ойлтууд нийвартан харагдана. Энэ нь өөжжилгийн зэрэгтэй хамааралтай явагдана. Үүнийг цайвар элэг гэнэ.

Үнэлэлт: Ультрасонографигаар эхлэн оношлох бүрэн чадацтай.

5. Элэгний цирроз. Статик сцинтиграфийн шинжилгээгээр доорхи хэв шинжит бөрчлөлтүүд илэрхийлжээ. Циррозын эхийн төрөл — эзги дэх илэрхийжиний шинмэгдэлт илзэнхүйдээ: багассан. Элгэнд жижгээс бүдүүн идэвхжилгүй толбонцорууд үүснэ. — элэгний зүүн дэлбэн илэрхий томорч, баруун дэлбэн багасч ирдэг. — дэлүү ямагт том байх бөгөөд ясны хэмэнд идэвхжилийн таркалт илэрхээ.

— циррозын тавиланг бидний санал болгосон сцинтиграммийн тоон үнэлэлтээр урьжчилсан үнэлж болно.

Үйл ажиллагааны сцинтиграммаар элэгний циррозын үе дэх элэгний үйл ажиллагааны алдагдлын зэрэгтэй хамааралтайгаар эмзэг бөрчлөлтүүд тодорхой илэрсэн байдаг нь шийжилгээний үрдүнд тодорхой харагдана.

Үйл ажиллагааны сцинтиграммийн үзүүлэлт (мин)

Элэгний цуллаг дахь Тмакс 20

Т 1/2 26

Элэгний дурслэл Баруун дэлбэн багасна зүүн дэлбэн томорно

Элгэн доторхи цесний цөргүүн дурслэл 26

Цесний гэрийн бүрэн дурслэл 26

Олон үед 32 мин-д дээд гэдэс дурслэгдхэг байдал 30

Тмакс, Т 1/2, элэгний дурслэлийн үзүүлэлтүүд нь хэв шинжит критери юм. Сцинтиграммийн училсэн хугацааны зургууд нь элгэн дэх динамик-биологийн байдал, перфузийт үзүүлэх толь юм.

Харин үйл ажиллагааны сцинтиграмм нь элэгний циррозын хэлбэрийг ялгаж чадахгүй байна. Иймээс энэхүү сцинтиграмм нь элэгний циррозын үе дэх үйл ажиллагааны алдагдлын зэрэг, эмчилгээний үе дэх өвчний явц уг өвчний тавиланг тогтооход үнэтэй шинжилгээний арга тэж үзнэ. Элэгний гепатографи нь элэгний үйл ажиллагааны алдагдлын зэргийт үнэлэхэд үнэтэй, мэдрэмтгий юм гэгдгийг дурдья.

Ультрасонографийн үзүүлэлт: Элэг нь ихэнх тохиолдолд билиар циррозын үед томордог бөгөөд, харин постекротик, порталь циррозын үед багассан байв. Голдуу элэгний баруун дэлбэн шуугдаж зүүн дэлбэн

илэрхий томордог нь гол шинж юм. Элэгний урд зах гүдгэр, жигд бус, элэгний өнцөг мохоо болдог. Орчны эд эрктэнээс ялгагдана. Элэгний хальс зузаарсан байна. Элэгний хэт авиан цуурай-бүтэц цоохор.

Бидний сонгож авсан элэгний циррозын гурван үндсэн хэлбэрийг элэгний цуурай-бүтэц «эхоструктур»-ийн хувьд ойлтын хэмжээ (цуурайн эрчимжил) ижил төрөлшил, ойлтын тархалт, ойлтын нягт, саарал утгын гистограмм гэсэн үзүүлэлтээр үнэлсэн юм.

Билиарь циррозын үед голдуу нарийн толбот, их эрчимтэй, харилцан адил тархалт ойлтын хэмжээтэй ижил төрөлшил алдагдсан ойлтын нягтат «том» элэг (хэт авиан суралт маш ихэссэн) ажиглагдана. Харин постnekrotik, порталь циррозын үед бүдүүлгэг толбот их эрчимтэй, харилцан адилгүй ойлтын хэмжээтэй илэрхий ижил төрөлшил алдагдсан, харьцангуй ойлтын нягтат «жижиг» элэг дурслэгддэг.

Саарал утгат-гистограммын үр дунг авч үзвэл элэгний циррозын дээрх гурван хэлбэрийн үед элэгний архаг гепатиттай харьцуулбал то-дорхой өндөр байгаа нь батлагдсан байна.

Элэгний вен царийссан, үүдэн генийн тогтолцсо өргөссөн нь үүдэн венийн даралт ихсэлтийг илэрхийлэх бөгөөд хэвлэлийд ус хуралдсан харгадана. Ийм байдал дурслэгдэх элгийг «хөвөгч элэг» гэж нэр тогтоов. Хүйсэн вен ($2,5 \pm 2,2$ см) 26 тохиолдолд буюу үүдэн венийн даралттай үед дурслэгдэв. Дэлүү байнга томорсон байдаг нь хэв шинж бөгөөд үүний «хавдсан дэлгүү» гэж нэрлэсэн. Дэлүүний «цуурай-бүтэц» нь ямагт ижил төрөлшилтэй, эрчимтэй байдаг.

Дээрх хэм хэмжээгээр үнэлэхэд оношлолын мэдрэг чанар 100%, өвөрмөц чанар 98%, оношлолын өрөнхий магад үнэн 100% байв.

Үнэлэлт: Элэгний циррозын оношлолд хэт авиан шинжилгээ өөрийн өндөр магад үнэнээрээ мэдрэмтгий сайн арга гэдэг нь нотлогдож байна.

Оношлогооны оновчтэй ерөнхий чиг баримжаа (стратеги):

- I. Хэт авиан оношлогоо (эхо)
- II. Үйл ажиллагааны сцинтиграфи
- III. Статик сцинтиграфи, (гепатограф)
- IV. Компьютерт томографи

Элэг цөсний архаг өвчинүүдийг эрт оновчтой оношлох дурслэл оношлогооны шаталсан хотёлбөр (программ)

1. Архаг холецистит
- I. Хэт авиан оношлогоо (эхо)
- II. Үйл ажиллагааны сцинтиграфи
2. Архаг гепатит
- I. Үйл ажиллагааны сцинтиграфи
- II. Гепатографи
- III. Хэт авиан оношлогоо (эхо)
- IV. Статик сцинтиграфи (компьютер томографи)
3. Өөхөжсөн элэг
- I. Хэт авиан оношлогоо (эхо)
- II. Компьютер томографи
4. Элэгний цирроз
- I. Хэт авиан оношлогоо (эхо)
- II. Үйл ажиллагааны сцинтиграфи (гепатографи)
- III. Компьютер томографи

Харилцан адилгүй ойлтын хэмжээтэй ижил төрөлшил алдагдсан ойлтын нягтат «том» элэг (хэт авиан суралт маш ихэссэн) ажиглагдана. Харин постnekrotik, порталь циррозын үед бүдүүлгэг толбот их эрчимтэй, харьцангуй ойлтын нягтат «жижиг» элэг дурслэгддэг. Билиарь циррозын үед голдуу нарийн толбот, их эрчимтэй, харьцуулбал то-дорхой өндөр байгаа нь батлагдсан байна. Дэлүү байнга томорсон байдаг нь хэв шинж бөгөөд үүний «хавдсан дэлгүү» гэж нэрлэсэн. Дэлүүний «цуурай-бүтэц» нь ямагт ижил төрөлшилтэй, эрчимтэй байдаг. Үүдэн генийн тогтолцсо өргөссөн нь үүдэн венийн даралт ихсэлтийг илэрхийлэх бөгөөд хэвлэлийд ус хуралдсан харгадана. Ийм байдал дурслэгдэх элгийг «хөвөгч элэг» гэж нэр тогтоов. Хүйсэн вен ($2,5 \pm 2,2$ см) 26 тохиолдолд буюу үүдэн венийн даралттай үед дурслэгдэв. Дэлүү байнга томорсон байдаг нь хэв шинж бөгөөд үүний «хавдсан дэлгүү» гэж нэрлэсэн. Дэлүүний «цуурай-бүтэц» нь ямагт ижил төрөлшилтэй, эрчимтэй байдаг.

НЯРАЙ ХҮҮХДИЙГ ЭРТ АМЛУУЛАХ ШИНЖЛЭХ УХААНЫ ҮНДЭС

**Ц. НАМСРАЙ
Ш. ЖАДАМБАА (Анагаах ухааны их сургууль)**

Аливаа бие махбод гадаад орчинд дасан зохицоход тэр биеийн макромолекулын төрөл түүний хэмжээ зайлшгүй өөрчлөгджэй физиологи-биохимиин үйл ажиллагааны зохицуулалт явагдаж байдаг. Өөрөөр хэлбэл эсийн бодисын солилцоо турван үндсэн асуудлыг шийдэх ёстой (6). Үнд:

1. АТФ мэт ихэнд энергитэй нэгдэл үүсгэж эсийг энэргиэр хангаснаар төрөл бурийн нэгдлийг шинээр нийлэгжүүлэх, химийн болон механик ажилгүйцэтгэх, зохицуулалт хийх боломжийг бүрдүүлиэ.

2. Тухайн бие махбодийн эсч хөгжих, оршин тогтоно нөхцөлийг хангагч өндөр молекулт нэгдлүүд (нуклеин хүчил, уураг, нүүрс ус, өөх тос)-ийг нийлэгжүүлэхэд зайлшгүй завсрлын буюу угтвар бодисуудыг бий болгоно.

зохицох процесст орж, оршин тогтоно нөхцөлөөр бүрэн хангагдана.

Судалгааны арга ба зорилго. Цусан хүй тасарч, «сүүн хүйтэй» холбогдож буй нярай хүүхэд гадны орчинд дасан зохицуулагч нь юу вэ? гэдэгт хариулах зорилго өвөрлөн эхийн ангир уургийн химийн найрлагыг сонирхон судалгааг явуулав. Судалгаанд Гелийн электрофорез, хий-шигээний хроматографи, атом шигээлтийн спектрофотометр болон сонгомол бусад аргуудыг ашиглав.

Судалгааны үр дүн. Судалгааны дүнгээс үзэхэд хүүхэд төрснөөс эхлэн 16 цагаас хойш ангир уураг дахь уургийн хэмжээ, түүний бүлэглэлд ихээхэн өөрчлөлт гарч байсан бөгөөд төрсөн даруйд ямар байсныг 1-р хүснэгтээр үзүүлэв.

1-р хүснэгт

Ангир уураг дахь уураг, уургийн бүлэглэл (2)

НИЙТ УУРАГ, %	УУРГИЙН БҮЛЭГДЭЛ, %				ҮНЭЭС %	
	СЕРАЛЬ БУМИН	ЛАКТО- ГЛО- БУЛИН	ЛАКТО- АЛЬБУ- МИН	ИММУНО ГЛОБУ- ЛИН	ЭЭДЭМ ЦЭР	УУСДАГ УУРАГ
	8,2	4,2	байхтүд	41,47	53,84	УГҮЙ

3. Бодисын солилцооны исээдэн ангижрах урвалд ямагт оролцдог биологийн антижуулагчид (НАДФ, НАДФН гэх мэт нуклеотид)-ыг сэргээнэ. Эдгээрийн үр дүн бие махбод биохимиийн дасан

Хүснэгтээс харахад бие махбодийн оршин тогтонохиын үндсийн үндэс болсон уургийн хэмжээ их, тэгэхдээ уусдаг уураг 100% үүний хагасаас илүү нь иммуноглобулин, цусны ийлдсийн альбуминаас өөр

шийнжтэй, хөхний бүлчирхайд галактозил трансфераза ферментийг лактаза-синтетаза болоход (I) идэвхтэй оролцдог физиологийн үйлчилгээтэй — альфалакто-альбумин 40% гаруйг эзэлж байхад хүүхдэд харшлын үйлчилгээ үзүүлдэг лактоглобулин тэрчлэн хялбархан боловсорч чаддагтгүй эзэмцэр гэх мэт уургууд угүй байна (2).

Хүүхдийн хамгаалах тогтолцоонд чухал үүрэгтэй фермент лизоцим, моноцит, лимбоцит, макрофаг зэрэг элементүүд (2, 3) нярайн ферментэн системийн кофактор болж биохимиин тасралтгүй урвалуудыг явуулах үндсэн үүрэгтэй биометаллууд (4) тухайн биесийн биологийн идэвхит нэгдлүүдийн урьтал бодис болдог үл орлогдох аминохүчил, бүх аминохүчлийн 40% гаруйг, мөн үл орлогдох тосны хүчил бүх хүчлийнхээ (5) 55% гаруйг тус тус эзэлж байгаагаас гадна шветта-лактоза нэйрлага тогтмолжсон сүүнийхээс бага байгаа буюу энэ изомер бусад сүүнд байхгүй (2).

Холестерийн, цэсний нийлэгжилтэнд идэвхтэй оролцож уураг тархины үйл ажиллагаанд нөлөөлдөг таурин болон бүх фермент, гормон, витаминынуд бүгд тодорхой хэмжээгээр агуулагдаж шилжилтийн болон найрлага тогтмолжсон сүү болоход хувь хэмжээ нь ба-гасч тэр ч байтугай дээр дурьласан эзэмцэр, лактоглобулин нийлэгждэг. Харин эзэмцрийн ижил цахилгаан цэнэгт цэгт харгалзах РН хүүхдийн хо-доодны орчинтой ижил бай-

даг нь ихээхэн ач холбогдолтойн гадна маш нарийн зохицолгоо юм.

Судалгаанаас үзэхэд нярай хүүхдийг гадна орчинд дасан зохицоход зохицуулагч нь антир уураг болж буй нь тодорхой байна. Ангир уургаар эрт амлуулж чадсанаар хүүхдэд илгээсэн «байгалийн бэлгийг» өөрөөр тухайн хүүхдийг цаашид эруул чийрэг осч хөгжих нөхцөлийг хангагч бүх угтвар бодисыг 100% олгоно гэсэн ойлголт болно.

Дүгнэлт

1. Ангир уураг нь нярай хүүхдийн бие махбодод зайлшгүй биологийн идэвхит бодисуудыг бүрэн агуулсан өвөрмөц, сонгомол биошингэн мөн.

2. Нярай хүүхдийг тадна орчинд дасан зохицох бүх нөхцөлийг гагихуу ангир уураг хангаж чадна.

3. Амлуулж хугацаа гэдгийг хүүхдийн анх мэйдлээд буй үеэс эхлэн ойлгойц.

4. Эхийн ангир уургийг өөр ямар ч сүүтээр орлуулж болохгүй.

АШИГЛАСАН ХЭВЛЭЛ

1. Э. Гааль, Г. Медьеши, Электрофорез в разделений биологических макромолекул. перев. с англ. М., Мир, 1989, стр. 367.

2. Ш. Жадамбаа, Сравнительное исследование белков и белковых фракций материнского молока и молока сельскохозяйственных животных автореферат, 1001. УБ.

3. Ч. Ишханд. бусад. Лизоцимийг хүүхдийн тэжээлд хэрэглгэх боломж. Анаагаах ухаан УБ. 1991. № 1. хуудас 28—29.

4. З. Ичинхорлоо. Сравнительное исследование динамики биоэлементов материнского молока. автореферат. УБ., 1992.

5. Б. Сүхбаатар. Исследование ди-

номики физико-химических показателей и жирных кислот грудного молока, автореферат, УБ., 1992.

6. П. С. Хочачка, Дж. Сомеро. Стратегия биохимической адаптации. Перев. с англ. М., Мир, 1977.

МОНГСЛХ ХҮНИЙ ЦУСНЫ АВО БҮЛГИЙН ТАРХАЛТЫГ СУДАЛСАН НЬ

Г. БАТМӨНХ (АУИС-ийн эрүүл физиологийн тэнхим)

Цус бол биеийн эрхтэн тогтолцоо, эд эсийг холбож, түүний зохицуулгад чухал уүрэг гүйцэтгэдэг учраас цусны найрлага, шинж чанарыг судлах нь эрдэмтдийн анхаарлыг татсан гол асуудлын нэг хэзээр байна.

Цусны бүлэг нь генээр удамших, насан туршид үл өөрчлөгдхө баттай шинж тэмдэг билээ.

Эрдэмтэд гадаргуугийн эсрэгтөрөгчийн шинжээр нь цусны улаан эсийг 9 том (24 жижиг) бүлэг болгон хувааж, улаан эсийн 500 дунччур гаруй фенотип байдгийг тогтоо жээ. (5, 8)

Энэ олон бүлгээс хамгийн илүү судлагдсан, практикт өргөн хэрэглэгддэг нь АВО систем юм.

Улаан эсийн эсрэгтөрөгчийн бүлгийн тархалт яс үндэснээс хамаарна. (3, 5, 8, 9)

Тус улсын хүн амын доторх цусны АВО бүлгийн тархалтыг Б. Од, Г. Батмөнх, Ч. Шарав, П. Нямдаваа, Ж. Батсуурь нар (1, 2, 3, 4, 6, 7) судалжээ. Гэвч тэдгээрийн судалгаа нь тодорхой нутаг дэвсгэрийн цээн тооны хүнийг хамруулж судалснаас ажлын цар хүрээ хязгаарлагдмал, судалгааны үр дунгийн үзүүлэлт нь улсын хүн амын дундажийг тогтоох нэгдмэл дүгнэлтэд хараахан хүрээгүй юм. Нэгээ талаар манай орны мэс засал, эх барих эмэгтэйчүүд, гэмтлийн эмнэлгийн практикт донорын шусыг ихээр хэрэглэж, байгаа нь цусны иөөцийг аврижуулалыг зүй ёсоорошаардах байна. Мөн монгол хүн судлалын асуудал исхояд дөн тавигдаж байгаа онөө үед цусны АВО бүлгийн тархалтыг уламжлэгэн хүрээтэй судлах асуудал анагаах ухаан, хүн судлал, угсаатны зүй судлал доноол практикийн чухал ач холбогдолтой юм. Иймд бид цусны АВО бүлгийн тархалт манай нийт хүн амын дотор ямар байгааг нэгтгэн дүгнэх, аймаг хотуудын хоорондын ялгаа, генийн давтамж ямар байгааг судлах зорилт тавив.

Судалгааны материал, арга зүй. АУИС-ийн Эрүүл физиологийн тэнхимиин лабораторийд 19—35 насны 2200 хүний цусанд АВО бүлгийг тодорхойлов. Цусны АВО бүлгийг тодорхойлоходоо Эрүүл мэндийн яамны харьяа Цус сэлбэлт ба судлалын төвийн бэлтгэсэн 1:32 титр бүхий 01, A11, B111 бүлгийн хоёр серийн «дугаарын» стандарт ийлдэсийг хэрэглэж, тасалгааны халуун хүйтэн, гэрэлтүүлэлт, тодорхойлох

хугацаа зэрэг зайлшгүй шаардагдах нөхцөл, хүчин зүйлүүдийг баримтлан нийтээр хүлээн зөвшөөрсөн судалгааны аргыг хэрэглэв. Энэ талаар хийгдсэн бусад судлаачдын судалгааг нэгтгэн дүгнэв. Цусны бүлэг тус бурийн хүний тоог бүх шинжлүүлэгчдийн өрөнхий тоонд харьцуулж цусны АВО бүлэг тус бурийн эзлэх хувийн харьцааг гаргаж дундаж алдааг тооцов.

Шинжлүүлсэн хүний цусны бүлгийг хүйсний байдлаар авч үзвэл:

Хүснэгт 1.

Энэ хүснэгтээс үзвэл цусны АВО бүлгүүдийн харьцаа хүйснээс хамаардаггүй нь харагдav.

Манай улсын аймаг, хотуудын нутгийн хүн амын дотор цусны АВО бүлгийн тархалт ямар болохыг судалж үзэв. Энэ нь хүн судлал, популяцийн генетик, угсаатны зүй судлаачдын анхаарал төвлөрдөг асуудлын нэг юм.

2-р хүснэгтээс үзвэл генийн давтамж аймаг, хотын хүн амд харилцан адилгүй өөр өөр түгэлттэй байна. Мөн баруун, төвийн зүүн, өмнө зүгийн аймгуудыг бусчилэн судалж үзэхэд ч бага боловч ялгаа ажиглагдав.

Энэ нь донорын цусны нөөцийг бүсчилэн бэлтгэхэд эрүүлийг хамгаалахын практикт чухал ач холбогдолтой юм.

Бидний энэ удаагийн тодорхойлсноор бүх шинжлүүлсэн 2200 хүний 785 хүн буюу $35,7 \pm 1,04\%$ нь ОI бүлэг, 527 хүн буюу $24,0 \pm 0,83\%$ нь АП бүлэг, 699 хүн буюу $31,8 \pm 0,98\%$ нь ВIII бүлэг, 189 хүн буюу $8,5 \pm 0,35\%$ нь АВIV бүлгийн цустай байв.

Эсрэгтөрөгч А ба В бүлгийн тоог авч үзвэл эсрэгтөрөгч А—32,5%, эсрэгтөрөгч В—40,3% байгаа нь монгол хүний цусанд эсрэгтөрөгч В зонхицж байдгийг харуулна.

Цусны АВО бүлгийн В ген монгол хүнд давамгайлж байгаа нь манай оронд эндеми маягтай байсан зарим халдварт өвчний эсрэг шигшилт явагдсантай холбогдолтой байж болох юм.

Цусны бүлэг үр удам дамжина. Гэхдээ генетикийн хуультай нарийн зохицож удамшил явагдана. Хүүхэд нэгийг нь эцгээс, нөгөөг нь эхээс авсан хос аллелиар удамшина. Энэ генуудийн харилцан үйлчлэлээс хамаарч эсвэл эцгийн шиг, эсвэл эхийн шиг эсвэл эцэг эхээс дамжсан генуудийн хослол гуравдах байдлаар удамшиж хүүхдийн цусны бүлэг бүрэлддэг.

Эцгийнхээ буюу эхийнхээ генийн аллелиар давамгайлж, удамшиж уу, эсвэл эцэг эхийн генийн аллелийн хослогоор удамшсан байна уу гэдгийг тодорхойлохын тулд эцэг эхийнхээ цусны бүлгийг баттай мэддэг 520 хүнд харьцуулсан судалгаа хийж үзлээ.

Хүснэгт 3

Цусны АВО булгийн эсрэгтөрөгчийн тархалт ба
хүснэгтийн хамаарал

Хүснэгт 1

Хүйс	Хүчин тоо	0I		III		Цусны АВО булэг		VII		AV/V	
		тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь
ЭР	485	175	36,1	117	24,1	131	27,0	62	12,8		
ЭМ	1715	610	35,6	410	23,9	568	33,7	127	7,4		
Бүгд	2200	785	35,7	527	24,0	699	31,8	189	8,5		

Цусны АВО булгийн эсрэгтөрөгчийн тархалт
(аймаг, хотоор ба бүсээр)

БҮС	Аймаг, хот	0I		III		VII		AV/V		
		тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	
Баян-Өлгий		60	22	36,7	14	23,3	19	31,7	5	8,3
Увс		87	31	35,6	23	26,4	27	31,0	6	7,0
Ховд		92	29	37,5	21	22,8	31	33,3	11	11,9
Завхан		110	43	39,1	19	17,3	41	37,3	7	6,3
Говь-Алтай		81	26	32,1	14	17,3	27	33,3	14	17,3
Дунд		430	151	35,1	91	21,2	145	33,7	43	10,0

ТӨРӨННӨССӨН НАМНДАР, ХОТ		Үргэлжлэл									
0	1	2	3	4	5	6	7	8	9	10	
Хөвсгэл	108	34	37,5	25	23,7	33	30,6	16	14,8		
Ардзангай	105	38	36,2	26	24,8	35	32,3	6	5,7		
Баянхонгор	79	34	43,0	13	16,5	24	20,4	8	10,7		
Булган	70	26	37,1	16	22,9	21	30,0	7	10,0		
Өвөрхангай	93	32	34,4	26	28,9	27	21,0	8	8,6		
Сэлэнгэ	66	20	30,3	24	36,4	18	27,3	4	6,0		
Төв	87	28	34,6	17	21,0	30	37,0	6	7,4		
Даажан	52	21	40,4	17	13,5	17	32,6	7	13,5		
Улаанбаатар	742	268	36,4	1783	24,7	237	32,0	54	7,2		
ДҮН	1396	501	35,9	337	24,1	442	31,7	116	8,3		
ЗҮҮННЭ СҮРННЭД		ҮЗҮҮЛСЭН НАМНДАР		ҮЗҮҮЛСЭН ҮРГЭЛЖЛЭЛ		ЗҮҮННЭ СҮРННЭД ҮРГЭЛЖЛЭЛ		ЗҮҮННЭ СҮРННЭД ҮЗҮҮЛСЭН НАМНДАР		ЗҮҮННЭ СҮРННЭД ҮЗҮҮЛСЭН ҮРГЭЛЖЛЭЛ	
Хэнтий	62	27	43,5	10	16,1	21	33,9	13,4	6,5		
Дорнод	70	22	31,4	26	37,1	17	24,3	5,5	7,2		
Сүхбаатар	67	19	28,4	16	23,9	25	37,3	7	10,4		
ДҮН	199	68	34,2	52	26,1	100	63	31,7	16	8,0	

Дундговь	63	20	31,7	20	31,7	19	30,2	4	6,4
Дорноговь	63	22	34,9	17	26,9	18	28,6	6	9,6
Өмнөговь	49	23	46,9	10	20,4	12	24,5	4	8,2
ДҮН	175	65	37,1	47	26,9	49	28,0	14	8,0
БҮГД	220	785	35,7	527	24,0	699	31,8	189	8,5±0,35

Хүснэгт 3

**ХЭНИЙ ГЕНЭР ДАВАМГАЙЖ УДАМШСАНЫГ
ХАРУУЛСАН УЗУУЛЭЛТ**

Хүйс	Хүний тоо		Эцгийн тоо		Эхийн тоо		Хосолсон тоо	
	Хүний тоо	Хувь	Хувь	Хувь	Хувь	Хувь	Хувь	Хувь
Эр	106 474	38 112	35,8 27,1	35 454	33,0 37,2	33 148	33 148	31,2 35,7
Эм								
БҮГД	520	150	28,6	189	36,3	181	34,8	

Хүснэгт 4

**МОНГОЛЧУУДЫН ЦУСНЫ УЛААН ЭСИЙН
АВО ВҮЛГИЙН ЭСРЭГТӨРӨГЧИЙН ТАРХАЛТ
(хувиар)**

Судлаачид хүний тоо	0I	AII	BIII	AB/IV
Б. Од (1961) 200	34,0	30,5	32,5	3,0
Г. Батмөнх (1964) 400	39,2	24,5	31,2	5,1
Ч. Шарав (1970) 2000	39,3	22,9	30,9	6,9
П. Нямдаваа (1976) 400	37,7	23,8	31,8	7,2
Ж. Батсуурь (1986) 9223	37,5	23,4	31,7	7,4
Г. Батмөнх (1993) 2200	35,7	24,0	31,8	8,5
Монгол хүний дундаж 14423	37,3±0,40	23,7±0,45	31,5±0,38	7,5±0,21

Хүснэгт 5

**ЦУСНЫ БҮЛГИЙН ТАРХАЛТ
(хувиар)**

Улс	Цусны бүлэг			
	0I	AII	BIII	AB/IV
Германчууд	37,1	42,9	15,5	4,5
Оросууд	40,7	31,2	21,8	6,3
Япончууд	26,3	36,0	23,4	14,4
Хятадууд	29,0	32,0	29,0	10,1
Энэтхэгчүүд	31,3	19,0	41,2	8,5
Буриалууд	30,4	21,9	37,8	9,0
Монголчууд	37,3	23,7	31,5	7,5

З-р хүснэгтээс үзвэл эрэгтэй хүүхэд эцгийнхээ, эмэгтэй хүүхэд эхийнхээ цусны бүлгийг дууриаж төрдөг хандлага бага боловч ажиглагдлаа.

Манай улсын хүн амын дотор цусны АВО бүлгийн тархалтыг судалсан судлаачдын шинжилгээний дүнтэй өөрийн энэ удаа хийсэн шинжилгээний үр дүнг харьцуулж эцэст нь монголчуудын цусны АВО бүлгийн тархалтыг нэгтгэж дүгнэв.

Хүснэгт 4

4-р хүснэгтээс үзвэл монгол хүний $37,3 \pm 0,40\%$ нь 01; $23,7 \pm 0,35\%$ нь АII; $31,5 \pm 0,38\%$ ВIII; $7,5 \pm 0,21\%$ ABIV бүлгийн цустай байна.

Эсрэгтөрөгч А ба В-ийн тархалтыг авч үзвэл эсрэгтөрөгч А— $31,2 \pm 0,38$; эсрэгтөрөгч В— $39,0 \pm 0,41$ байна.

Монголчуудын цусны АВО бүлгийн эсрэгтөрөгчийн тархалтыг бусад улсад хийгдсэн судалгаатай харьцуулж үзье.

Хүснэгт 5

Энэ хүснэгтээс үзвэл дэлхийн яз бурийн орнуудын үндсэн хүн амд цусыг АВО бүлгийн тархалт өөр өөр байдаг нь харагдаж байна. Иймд монгол хүний цусны бүлгийг нарийвчлан судлах нь чухал юм.

ДҮГНЭЛТ:

1. Монгол хүний цусны АВО бүлгийн тархалт 01— $37,3 \pm 0,40\%$; АII— $23,7 \pm 0,35\%$; ВIII— $31,5 \pm 0,38\%$; AB IV— $7,5 \pm 0,21\%$ байна.

2. Монголчуудын А—эсрэгтөрөгч $31,2 \pm 0,38\%$, В—эсрэгтөрөгч $39,0 \pm 0,41\%$ байгаа нь Европын хумуустэй харьцуулахад манай хүн амын цусанд В—эсрэгтөрөгч зонхицж байна.

3. Цусны АВО бүлгийн тархалтыг аймаг, хотоор ба бүсчил эн судлахад бага боловч ялгаа ажиглагдаж байгаа нь аймаг, хот бүрээр ба бүсчилсэн донорын цусны нөөцийг аврижуулахад чухал юм.

АШИГЛАСАН ХЭВЛЭЛ

1. Г. Батмэнх. Монгол хүний цусны бүлгийг тодорхойлох асуудалд «АУДС-ийн эрдэм шинжилгээний бичиг» 1967, № 2, 112—115

2. Ж. Батсуурь Монгол хүн амцах цусны АВО бүлгийн түгээлт Ерөнхий ба сорилын биологийн хүзээлэнгийн эрдэм шинжилгэгний бүзэл. 1977, № 11, 5—7

3. Ж. Батсуурь Наследственный полиморфизм и география народонаселения Монголии. Автореферат докт. дисс., М., 1986

4. Г. Дашиэвэг, П. Нямдаваа, Д. Эрдэнэсамбуу. Хүний биеийн бу-

тэц, үйл ажиллагааны хэвийн хэмжээ. УБ. 1980. 125—134

5. Конюхов В. В., Пашин Ю. В. Наследственность человека. М. 1971.

6. Б. Од. Монгол хүний цусны бүлгийг судлах асуудал ба түүний ач холбогдол «МУИС-ийн эрдэм шинжилгээний бичиг» 1961, ф 2 121—125

7. Ч. Шарав, Групповые свойства крови у монголов. Автореферат канд. дисс., М. 1970

8. Физиология человека. Пол. ред. Р. Шмидта и Г. Тевса, том Ш. М., 1986

9. Физиология системы крови, Л., 1968

Лекц тойм зөвлөгөө

МОНГОЛ УЛС ДАХЬ МАЛЧДЫН ӨВЧЛӨЛ ЭМНЭЛЭГ ҮЙЛЧИЛГЭЭ-НИЙ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

П. ЯНСАН Анагаах ухааны хүрээлэн

(Нэг сэдэвт зохиолын хураангуйши бөвч)

Монгол орны нийгэм улс төр, эдийн засгийн өөрчлөлт нь эрүүл мэндийн салбарын тогтсон хэв шинж, үйл ажиллагаа, хүн ам ялантуяа малчдын ажил үйлдвэрлэл, ахуй нөхцөл, эрүүл мэндэд хүчтэй нөлөө үзүүлж, сөрөг үр дагавар даваачгайлах боллоо.

Манай малчдын эрүүл мэнд, эмнэлгийн тусlamж нь байгаль газар зүй, цаг уур, мал аж ахуйн үйлдвэрлэл, нутагшмал нягтралтай ихээхэн хамааралтай, өвөрмөс онцлогтой билээ. Хөдөөгийн хүн амын эрүүл мэнд, эмнэлэгт үйлчилгээний зарим асуудлаар судалгаа шинжилгээний нилээд ажил хийгдсэн боловч малчдын, эрүүл мэнд, эмнэлгийн тусlamжийг тусгайлан судалсангүй едий хүрсэн юм.

Малчдын өвчлөл, эмнэлгийн тусlamжийн болит байглыг судалж, цаашид зохион байгуулах арга хэлбэрийг нь боловсронгуй болгох зорилттой уялдуулж:

а. Малчид тэдний гэр булийн хүмүүсийн өвчлөл;

б. Бага эмчийн салбар, нүүдлийн амбулатори, сумын эмнэлгийн тусlamжийн байдал, хэмжээ;

в. Малчдын эрүүл мэндийн илэвхтэй хяналтын («испансерчлал») онцлогийг судлах зэрэг зорилго тавьсан болно.

Шинжлэх ухааны шинэлэг тал нь:

1. Монгол орны нэхийэлд малчдын өвчлөлийг (эмнэлэгт ирэлт, бурдмэл узлаг, эмнэлэгт хэвтсэн ЭМИХ-ын иж бүрнээр анх удаа судалсан;

2. Хөдөөгийн хүн ам, малчдын эрүүл мэндийн үзүүлгээг өөрийн оронд анх удаа тогтоосон;

3. Малчдын эрүүл мэндийн илэвхтэй хяналтын (ЭМИХ) шинжлэх ухаан практикийн түвшилт үзүүлж үр дунг тооцсон;

Шинжлэх ухаан-практикийн ач холбогдол нь:

1. Уг судалгааны ажлын үр дуньш малчдын эрүүл мэндийг хамгаалах, эмнэлгийн тусlamжийг боловсронгуй болгох шинжлэх унდэслэл болсон;

2. Монголын хүн амын эрүүл мэндийг сайжруулах, эрүүл мэндийн салбарыг хөгжүүлэх 2005 он хүртэлэх чадсан чиглэл, малчдын эрүүл мэндийг хамгаалах 2000 он хүртэлэх хөтөлбөр, хөдөөгийн эрүүлийг хамгаалахын хөгжил байршилын схем зэрэгт тусгагдан хэвэргэжиж байна.

Судалгааны тажлын аргачлал: Малчдын өвчлөлийг эмнэлэгт ирэлт (узүүлэлт), хэвтэлтийн материалаже судалгааны тусгай картанд хуулбарлах, эмч нарын бүрлмэл үзлэгийг 10 гаруй нарийн мэргэжлийн эмч, бүрэв шинжилгээтэйгээр хийж үр дунг «үзлэгийн картанд» бичих, малчдын эрүүл мэндийн илэвхтэй хяналт (ЭМИХ)-ыг шинжлэх ухаан практикийн түвшилтын аргаар 3 уе шатаар;

Бага эмчийн салбарыг «өрхийн эрүүл мэндийн дэвтэр» гэсэн судалгааны тусгай картаар, эмнэлгийн явуулж тусlamжийг аймгийн нүүдлийн амбулаторийн үзлэгийн материалыг «нүүдлийн амбулаторийн ажил судлах карт»-нд хуулбарлах аргаар тус тус судлаж өвчлөл, ЭМИХ, бага эмчийн салбар, нүүдлийн амбулаторийн судалгааны материалд эксперт үзэлгээ өгүүлэв.

Судалгааны бааз, ажлын хэмжээ; Малчдын өвчлөл, бага эмчийн салбар болон ЭМИХ-ын судалгааг монгол орны байгаль газар зүйн яз бүрийн бүс, малчдын нас хүйс, ажил үйлдвэрлэл, эмнэлгийн үйлчилгээ, тусlamжийг төлөөлж чадах Хөвсгөлийн Их-уул, Булганы Орхон, Хэнтийн Дархан, Сүхбаатарын Баян-дэлгэр Эмнөговийн Ханхонгор суманд,

Эмнэлгийн явуулын тусlamжийг Ховд, Хөвсгөя, Дорнод, Дундговь аймгийн нүүдлийн өмбөлдөрийн үйл ажиллагасанд баазлал явуулсан болно.

Малчдын өвчлөлийг эмнэлэгт ирэлтийн материалыар судлахад эмч нарын бурдмэл узлэгээр 7944, ЭМИХ туршилт судалгаанд 2830, бага эмчийн салбарын ажлын судалгаанд 1992, эмнэлгийн явуулын тусlamжийн судалгаанд 4074 хүн буюу нийтдээ 24789 хүн хамрагдсан нь уг судалгаа нь ажлын хэмжээ Үр дүнгийн хувьд бүрэн хангалттай, үнэн магадлалтай болсныг харуулж байна.

Судалгааны ажлын үр дун:

Эмнэлэгт ирэлтийн байдлазар 1000 хүнд 660,2 промели (насанд хүрэгсэд 690,0 промели, хүүхэд 621,0 промели) өвчлөл ногдох байна. Судлаачдын материалыар монголын хөдөөний хүн амын өвчлөл 1000 хүн амд 755,5—1149,0 промелийн хооронд хэлбэлзээх бэйсан нь бидний судалгааны зарим баазад мөн ажиллагдаж байв. Өвчлөлийн хамгийн өндөр түвшин 0—3 насны хүүхдэд буюу 1000 хүнд 1181,5 промели тохиолд байна. Насны бүлэгт ахих тутам өвчлөлийн түвшин нэмэгдэж 40—49 насанд 714,0 промели, 50—59 насанд 667,1 промели, 60—69 насанд 806,6 промели байна.

Өвчлөлийн түвшин, бүтцийг хүйсээр авч үзэхэд эмэгтэйн өвчлөл эргтэйгээс илүү бөгөөд эхний 3 байр эзэлж байгаа ангилалын өвчлөлийн түвшин сүрэлжлийн IV байранд эргтэйд мэдрэлийн тогтолцоо мэдрэхүй эмэгтэйд шээс бэлгийн эрхтний өвчин орж байна.

Архаг өвчин эмэгтэйчүүдэд эрэгтэйчүүдээс 1,1—1,2 дахин их байгаа нь статистикийн үнэм магадлалтай $t > 2$ байна.

Өвчлөлийг эмнэлэгт ирэлтийн байдлаар судлахад амьсгалын (305,0) хоол боловсруулах (84,0) цусны эргэлтийн тогтолцоо (65,2), мэдрэлийн тогтолцоо, мэдрэхүй эрхтний (37,6), шээс бэлгийн эрхтний (35,1) өвчлөл нийт 5 байранд байгаа нь нийт өвчлөлийн 79 хувийг эзэлж байна.

Амьсгалын эрхтний өвчлөлийн дотор амьсгалын дээд замын үрээсэлт өвчин (58,8%) ушшины хаталгаа (26,4%), цусны эргэлтийн тогтолцооны өвчлөлийн дотор гастрит дуоденит (41,7%), мэдрэлийн тогтолцоо мэдрэхүй эрхтний өвчлөлийн дотор нүдний төрөл бүрийн өвчин (45,2%), шээс бэлгийн эрхтний өвчлөлийн дотор иефрит (36,6%) өвчин тус зонхицж байна.

Эмч нарын бурдмэл узлэгээр илэрсэн өвчлөлийг урьд нь эмнэлэгт илрэлтээр бүртгэгдсэн, цоо шинээр анх илэрсэн гэж 2 хувгаж үзэхэд маличил, тэдний гэр бүлийн 1000 хүнээс 583,0 промели өвчлөл анх удаа илэрсэн нь нийт өвчлөлийн 46,9 болж байна. Өөрөөр хэлбэл малчдын 81,0% тэдний хүүхдийн 32,6%-д «шинэ» өвчин илэрсэн байна.

Эмнэлэгт ирэлтийн болон эмч нарын узлэгийн материалыар өвчлөлийг харьцуулж үзэхэд нийгэмээрүүл мэндийн холбогдол бүхий олон архаг өвчин цоо шинээр анх илэрч оншлогджээ.

Тухайлбал: бодисын солилцооны хямрал, дотоод шүүрлийн тогтолцооны нийт өвчиний 78,0 мэдрэлийн тогтолцоо, мэдрэхүй эрхтний өвчин 67,1, хоол боловсруулах эрхтний өвчиний 70,8 хувь нь тус тус анх удаа илэрчээ. Энэ нь нэг талзас малчдын ажил байдал, үйлдвэрлэл ахуйн боллоюу муу, эрүүл мэндээ хангалтгүй анхаардгаас тэдний 40 гаруй хувь нь жилийн туршид сучынхаа эмнэлэгт ирж үзүүлдэггүй, т.г.г. талаас эмнэлгийн байгууллагын статистик бүртгэл хангалтгүйгээс өрчлөл дутуу бүртгэгддэг зэрэгтэй холбоотой гэж үзнэ.

Эмч нарын узлэгээр илэрсэн нийт болон анх удаа илэрсэн өвчлөл дотор хоол боловсруулах эрхтний өвчин зонхицж байгаагаас анх удаа илэрсэн нь 1000 хүнд 214,1 промели байна.

Эмч нарын узлэгээр хүүхэд 326,9

(эр 317,1, эм 337,4) насанд хүрэгсдэд 810,0 (эр 737,7, эм 864,8) архаг өвчлөл шинээр илэрсэн байна.

Корреляцийн аргаар өвчлөлийн түвшин насны бүлгийн хооронд шууд хүчтэй холбоо илэрч байна.

($r = \pm 88$)

Малчдын эмзилэгт ирэлтийн материалыар бургзгэсэн өвлөл, эмч нарын үзлэгээр анх удаа илэрсэн өвчлөлийг ингэгтэн нийт буюу «үүзн» өвчлөлийг гаргахад 1000 хүнд 124,0 промсели (эр 1179,7 эм 1300,1) байгаагас өмсгэл (338,5), хоол боловсруулах (298,1) цусны эргэлтийн (148,3) мэдрэл мэдрэхий (114,4), шээс бэлгийн эрхтэн, системийн өзчин эхийн 5 байранд буюу нийт өвчлэхийн 78,7 хувийг эзэлж байна.

Сумын эмзилэгт ирж үзүүлэгсдийн 22,0 хувь буюу жилд 1000 хүний 123,6 нь хэвтэн эмчлүүлж байгаачийн 15—17,8 хувь нь малчид байна.

Амьсгалын (64,5), хоол боловсруулах эрхтний (15,8), халдварт паразитын өвчиний (10,9), цусны эр-

лийн (субкомпенсацii) 0,2 хувь нь эзэгшил алдагдсан (декомпенсацii) байдалтай байна.

Малчдын архаг өвчлөл тогтоосон үидсэн дээр ЭМИХ-ын З жилийн туршид орхийн хэлбэрээр явуулажад 1000 хүн амд ногдох 922,2 промели хур өвчлөлийн 357,3 хувь нь хяналтанд хамрагдсанас хяналтын нийт хүний 20,4 хувь нь хоол боловсруулах эрхтний, 15,0 хувь нь цусны эргэлтийн тогтолцооны өвчиний учир хяналгээ.

Хяналтын 100 өвчтэнд ЭМИИН 231,0 рашаан сувиллын 2,8, урьдчилан сэргийлэх 12,0, нөхөн сэргээх 14,4 эмчилгээ, эмзилэгт хэвтэлт 14,7 лабораторийн 19,1 шинжилгээ ногдох буй нь хоол рашаан сувилзал, нөхөн сэргээх, параклиничийн туслаамж хөтөөд маш хэнгалтгүй байгааг харуулж байна.

ЭМИХ-ын үр дүн нь эрүүл мэндэд гарсан өөрчлөлт буюу эрүүл мэндийн бүлгийн шинжилтээр тодорхойлогдоно.

Булэг (хувиар)

ЭМИХ-ын хүмүүсийн эрүүл мэндийн

Эрүүл мэндийн бүлэг	Түршилтын эхэнд	Түршилтын эцэст (3 жилийн дараа)
I	0	34,6
II	43,3	30,0
III	37,0	27,0
IV	15,1	5,4
V	4,6	3,0
Дун	100,0	100,0

тэлтийн тогтолцооны өвчинеөр (5,5) зонхилон хэвтэж байна.

Хүүхлийн хувьд 1000 хүнд амьсгалын (92,2), хоол боловсруулах эрхтний (18,3), халдварт паразит өвчиний (15,8) зонхилон хэвтэж байгаа нь нийт хэвтэлтийн 37,2 хувийг эзэлж байна.

Бид өвчлөлийн судалгаан дээр үндэслэн малчдын эрүүл мэндийн бүлгийн үнэлгээг анх удаа тогтоов.

Эмч нарын бурдмэл үзлэгийн дунгэрээр 33,4 хувь нь цоо эрүүл буюу I, 21,9 хувь нь архаг өвчинигүй боловч эрхтэй тогтолцооны үйл ажиллагаа, ны өөрчлөлттэй буюу II, 44,7 хувь нь архаг өвчтэй буюу III, IV, V бүлэгт үүнээс 42,2 хувь нь архаг өвчтэй боловч эзэнгэшийн (компенсацii). 2,3% нь хагас эзэнгши-

гүснэгтээс үзэхэд түршилтын хугацааны эмчлэн эрүүлжүүлэх арга хэмжээний үр дүнд 34,6 хувь нь I бүлэгт шилжиж, IV, V бүлгийн эзлэх хувийн жин багассан байна.

Судалгаагаар 1000 хүн амд эмчилгээ зөвлөгөөний 3611 буюу нэг өвчинд 2,6 үзлэг ногдох, малчдын нутаглах зайд холдох бүр үзүүлэлт ховордож 40,0 хувь нь жилийн туршид сумын эмзилэгт ирж үзүүлдэггүй эмзилгээс 10 км холдох тутам 1000-аас 10 гаруй үзлэг багасч байна.

Эмзилэгт хэвтэгедийн 81,6 хувь нь сумын 17,2 хувь нь аймгийн 1,2 хувь нь улсын, эмзилэгт, 83,1 хувь нь нэг, 12,2 хувь нь хоёр, 3,3 хувь нь гурав, 1,4 хувь нь 4 ба түүнээс дээш удаа хэвтэж байна.

Нүүдлийн амбулатори өлөрт 60—70 хүн үзэж үзүүлэгсийн 63,6 хувь нь өөрдийн хүснэгтээр 36,4 хувь нь сумын эмчэлгийн заалт зөвлөөний дагуу үзлэгт орж 1000 хүн амд 1082 промел өвчлөл, 3843,3 үзлэг 900,6 шинжилгээ ногдох байна.

Малчлын 17,0—20,0 хувь нь үзлэгт хамрагдахгүй байна.

Бага эмчийн салбар нь 80 ± 15 ерх, 30—40 км радиуст үйлчилдэг.

Нийт үзлэгийн 90 хувийг гэрээр хийдэг, жилээ 1000 хүнд 2105,1 үзлэг ногдох байна. Бага эмчийн салбарас малчид холлох тутамт үзлэг багасч байна. Үүнээс 10 км хүртэл 3,1, 10—20 км-д 2,7 20—30 км-д 1,1, 30—40 км-д 0,3, 40өөс дээш км-д 0,09 үзлэг ногдох байна.

ДҮГНЭЛТ

1. Малчдын эрүүл мэнд эмнэлгийн тусламж нь олийн засаг, нийгэм огуул ахуй, байгаль наа уур, мал аж ахуйн үйлдвэрлэлтэй ихээхэн хөлбоост, өвөрмоц онцлогтой байна. Эмнэлэгт үйлчилгээний 5 шаталдаа бүх үзслэгийн 85,5, хэвтэлтийн 81,6, ЭМИХ-ын 94,0 хувийг эзлэдэг сумын эмнэлэг гол үүрэг гүйцэтгэж байна.

2. Малчид тэдний үр хүүхдийн 1000 хүнд эмнэлгийн ирэлтээр 660,2 промели, эмч нарын үзлэгээр анх удаа шинээр 588,0 промели өвчлөл илрөч нийт буюу «үүин» өвчлөл 1243 промели (өр 1179,7, эм 1300,1) байна. Нийт өвчлэлд амьсгалд хоом болворуулах, цусны өргөлт, мэдрэлийн систем чиглэлүүдийн өрхтний болон шээс бэлтийн замын өгчлөл зонхиж 78,7 хувийг эзлж байна.

3. Эрүүл мэндийн 5 бүлгийн шалтуураар үзэхэд малчид (сумын хүн

ам)-ын 33,4 хувь нь 1, 21,9 хувь нь III, IV, V бүлэгт хамарагдаж байна.

4. ЭМИХ-ын шинжилгэх ухаан практикийн туршилтын үр дүнд хур өвчний 38,7 хувь нь хяналтанд орж ихэнх нь (41,3—60,1 хувь), хүүхэд дотрын эмчид хянацдах, хяналтын үр дунгийн үзүүлэлт Матрицын аргаар 30,4 хувь байна.

5. Манай срны нехцэлд малчдад үзүүлэх эмнэлэгт ариун цэврийн тусламжийн нүүдлийн амбулатори, бага эмчийн салбарын үүрэг, энх холбогдол их бөгөөд 1000 хүн амд нүүдлийн амбулаторийн үзлэгээр 1082 промели өвчлөл, 900,6 шинжилгээ, 3843,3 үзлэг, бага эмчийн 2105,4 үзлэг ногдох, эмнэлэгт үзүүлэлт малчдын иутаглах зай хэмжээнээс ихээхэн хамаарч байна.

Судалгааны үндсэн дээр: Малчлын эмнэлэгт үйлчилгээг сум, аймаг улсын түвшинд, сумын эмнэлгийн орхийн, бага эмчийн салбарыг багардын аж ахуйтан дундын, томоохон зарим сумд хооронд бусийн эмнэлгийн хэлбэрээр зохион байгуулах,

ЭМИХ-ыг орхийн эмчийн хэлбэрээр нэг эмчид 120—130 архаг өвчтэй хүнээр тооцох, судалгааны яцад үр дунгээ харуулсан «өдрийн эмчилгээний түр салбар», «кэрүүлжүүлэх бригад» зэрэг явуулын тусламжийг малчдын ажийн үйлдвэрлэлэд, ахуй нехцэл, эрүүл мэндийн онцлогтой тохиуулсан зохион байгуулах зорэг практик санаалыг дэвшүүлсэн байна.

Нэг сэдэвт зохиолын санааг судлаачдын бичиж нийтлүүлсэн 36 бүтээлд тусгаж, хэвлэлийн 238 эх үүсвэр алшигласны 180 нь гадаадын хэвлэлийн материал байна.

АРИУН ЦЭВРИЙН СОӨЛЫН УЛАМЖЛАЛЫГ СУДЛАХ АСУУДАЛ

Г. ЦЭРЭНЖИГЖИД (АУИС)

Хөдөлмөрчдийн ялангуяа хүчинд өсвөр үсийнхийн ариун цэврийн соөлийн түвшин өндөр байх нэг сэжжим нь манай ард түмний соөлийн дэвшилтэгт уламжлалаас суралцах явдал юм. Монгол ардын зүйр цэниен уг, оньсого, үлгэр зэрэг монгол «То вангийн сургаал», Ц. Цэрэн

ардын аман зохиол, Ж. Д. Карпини (Итали), К. Хемфри (Англи), А. Б. Бурдуков (Орос) Г. Д. Рубчук (Франц) Марко Пало (Итали) зэрэг судлаач эрдэмтдийн түүрвисан Монголын тухай зохиол бүтээл, «Монголын нууц товчоо», «Алтан товч»,

«Монголын ёс» зэрэг бүтээлүүдэд ариун цэврийн уламжлалт сөйлийн холбогдолтой мэдээлэл олонтаа орсон бөгөөд тэнд эрүүл энхийн гайхамшиг, элдэв өвчин өмгэгийн хор уршиг, элдэв өвчинээс сэргийлж, энх тухын схавын учир холбогдлыг тал бүрээс нь элбэг тохиолдлоно.

Бид, монголын ард түмний ариун цэврийн уламжлалын тухай авч үзэхдээ ард түмний дунд олон зууны турш ярьж хэлэлцэж далайн ёроол дахь шүр сувд мэт тунаж үлдсэн монгол ардын 10000 гаруй цээн үгийн эмхэтгэл болох «Монголын цээн үгийн далай» хэмээх хоёр дэвтэр бүтээлтийг тулгуур болгон, үүний өмнө нэрийг нь цуhas дурьдсан XIII—XIV, XV—XYI, XYII—XX зууны зарим гол бүтээлүүдийг тусгаж, түүхчилсэн судалгааны арга хэрэглэсэн болно.

Эл бүлгийн утга санааг товч боловч цэгтэй гаргахын тулд монгол ардын зүйр цэцэн үгийг 4 бүлэг, 12 хэсэгт хувааж, дээрх зохиол бүтээлүүдээс зохих бүлэгт нь оруулж, и nemээлт тайлбар хийсэн болно.

1. Хувийн эрүүл ахуй

Манай ард түмэн хэзээнээс цэвэр цэмцгэр байдлыг эрхэмлэж, бага балчраасаа биеэ өөд татаж явахыг хичээсээр иржээ. Өөрийөө зэнд нь орхиж хир буртагтай явах нь хүний гоо үзээмжийг гутааж, сургийн дарж, уруу дорой харагдуулдагийг «Хамрын нус царай дарна. Биеийн бохир сүр дарна» гэж урнаар дүрслэн, үр хүүхэддээ «Түүр гарсаа угааж яв. Нус, нулимсаа арилгаж яв» гэж захидааг байв. Бохир буртаг байвал элдэв өвчинд өртөж болохыг «Заваан хүн өвдөх нь олон. Залхуу хүн үүрэглэх нь олон» гэж оночвортай зүйрлэн өгүүлж цэвэр цэмцгэр байхыг ямагт эрүүлмэж, гарсаа угаагаатгүй гал тогоонд хүрэх, идээ боловсруулах, хоол ундаа бэлдэхийг цээрлэдэг.

Элдэв зүйлээр цаг заваа өнгөрөөж сухын оронд биеэ өөд таталыг чухалд үзэж «Худал хэлж сурхаар хумсаз авч сур. Хулгай хийж сурхаар гутлаа уллаж сур» гэж сургаж байжээ.

Бохир буртаг явах нь гоо сайхны хувьд энгүй төдийгүй элдэв өвчин өмгэгт өртдөгийг сургамжлан «Буртгаа угааж цэвэр болно. Бу-

руугаа хэлбэл нэхэр болно», «Бүгдээр хэлэлцвэл буруугүй, бүлээн усаар угаавал хиргүй» гэж ярилцаж, энэ ёс зүйг баримталж иржээ. Хүн бага балчраасаа цэвэр няմбай явбал гоо сайхан харагдах төдийгүй, энэ чанар насан туриш хадгалагдан үлдэгийг «Цээн хүнд уг мундахгүй, цэвэрч хүнд бузар мундахгүй» гэж зүйрлэн өгүүлж цэвэр няմбайг эрхэмлэвэл эрүүл чийрэг байж, хөдлөмж, сурлагын амжилт олно хэмээн сургадаг.

Жиованини Дель Карпини «Монголчуудын түүх» бүтээлдээ гараараа барьж, тос ёх болгоод, гарсаа алчуурт арчих, хувцас, өвс ногоонд арчдаг» гэж эл үомын Хоол хүнсний тухай булагт тэмдэглэсэн байхад, Гильм Дэ Рубрук «Дорио этгээдэд зорчсон минь» бүтээлтээ «Нүүр гарсаа угаадаа урьдаар ус балгаж, хоёр гар дээрээ гоожуулан ус толгойгоо угаадаа» гэж тэмдэглэжээ.

Тэгвэл Оросын эрдэмтэн И. М. Майский «Хувьсгалын босгон дээрх монгол» (1960) «комынхоо «Эгүүл ахуй, ариун цэвэр» гэдэгт хэсэгт «Монголчуудын амьдралд ариун цэврийн дадал заншил тэр бүр тогтоогүй тэд саван ер хэрэглэдэггүй. Нуур гарсаа хүйтэн усаар булхдаг бөгөөд усанд ер ордоггүй. Өмссэн хувцсаа ч угаадагтгүй» гэж явуулын хүний нүдээр харснаа бичиж тэмдэглэсэн нь бий.

Англи улсын Кэмбрижийн их сургуулийн Монгол судалын төвийн захирал Лэролайн Хэмфри «Монгол хүний биеэ явч явдаг няг зуун ёс» (1989) өгүүлэлдээ «Өглөө босч гадаа гарч, биеэ засаад, хувцас сав юмуу үнсруу нүүр гарсаа угаана. Нойтон үнсийг дараа нь гаргаж асган» гэж бичсэн байхад судлаач Ц. Цэрэн «Монголын ёс» (1991) бүтээлдээ «Бүсгүй хүн сам шүүрээ хүнтэй сольдоггүй. Бүсгүй хүн гар, хелийн хумсаа хэт ургуулдагтгүй. Монголчуудын шүд бараг өвддэгтгүй байсан нь цагаан идээ идээдэгийн эч гэж үзлэг. Өглөө босч биеэ засахдаа шүдээ сайн зуудаг» гэх мэтээр монголчуудын биеэ авч явахтай холбоотой ариун цэврийн сөслийн уламжлалаас судлаач бүр зүсэн, харсан, мэдсэн, дуулсан бичиж тэмдэглэсэн нь олонтаа.

1. 2. Гэр орны эрүүл ахуй

Монгол ардын цэцэн үгэнд «Би-еэ тохижуулж байж, гэрээ тохижуул, Гэрээ тохижуулж байж улсaa тохижуул» хэмээх өгүүлсэн нь өөрийгээ асарч чадахгүй хүн бусдыг гасарч халамжилж, орон гэрээ тохитой авч явж чадахгүй болох тухай өргөн утгаар авч үзжээ. Үнэндээ ч айл өрхөөс аймаг, хошуу, улс орсон бүрддэг билээ.

Тогтохтэр (1797—1868) вангийн бүтээл «Тө вангсын сургаалын дээр дайчлан хөдөлж ажиллахыг ухуулж, үр хүүхдээ эрхлүүлэхийг үл таашааж, харин гэр малын ажилд сургаж, идэх, өмсөхийг өөрсдөөр нь олуулахыг шаардаж байсан нь зах зээлийн бодлогыг хэрэгжүүлж байгаа тухайн энэ зурсас үед ач холбогдоо алдаагүй байна. Тухайлбал: «Биеийн амрыг харж дэмийн сууваас нойр хүрэн унтаад, аж төрөхийг алдах, арай сэргж босвол дахин цай ууж, байсан бүгдийг идэх, гурван өдрийн уух цай, идэх хоолыг нэгэн өдөр барна» гэжээ. (Ш. Нацагдерж «Тө ван түүний сургаал» номын 105 дугаар талд)

Гильом Де Рубрук дээр нэрлэсэн номынхоо «Тэдний гэр орны тухай» бүлэгтээ «Тэд эсгийг гэрт суудагаа гээд 22 үхэр хөллиөсөн гэр тээрэг үзсэнээ бичсэн байхад судлаач Ц. Цэрэн Монголчууд «Гал руу хог нөвши, муу юм өр оруулдаггүй. Нүүхдээ гэрийн буурь хот хороогдоо газэржээж үзгээдэг» тухай онцлог тэмдлэглэжээ.

1. 3. Хувцасны эрүүл ахуй

Монголд «Сайн хувцас биед гоо. Сайн нөхөр сэтгэлд тоо» гэдэг цэцэн уг байлаг нь биедээ тохицуулж, цэвэр үзэмжтэй хувцаслагыг манай ард түмэн хэзээнээс эрхэмлэж ирсэний тодорхой жишээ юм. Хувцсаа шинээс нь хямгадахыг «Би-еэ залуугаас нь. Хувцсаа шинээс нь» гэж билдний эцэг өвөг эрхэмлэдэг. Нээрээ ч арчилгаа муугаас элэгдэж муудсан хувцас эргэж шинэчлэгдэхгүй.

«Тохиирогуу хувцас нүдний булаг, тослоогуу тэрэг чихний чийр» гэдэг цэцэн уг хувцсаа биедээ тохицуулж өмсөхийг эрхэмлэн захиж байгаа хэрэг.

«Монголчууд улираалд тохицуулж хувцсаа Хятад болон Дорно зу-

гийн бусад улс орон түүнчлэн Перс зэрэг өмнөдийн орнуудаас авна. Тэндээс торго, алтан саа бүхий бус дааеуу, мөн ихэмэл эдлэл авч зүй дээл (тэрлэг Г. Ц.) хийж өмсөнө. Тэд өвлийн цагт ихэвчлэн хоёр дээлтэй байна. Нэгний нь үсийг дотогши харуулж хийсэн, нөгөөг нь үсийг нь цас, салхинд гадагш харуулж хийсэн (дах, дэгтийн бололтой? Г. Ц.) дээл өмсөнө.» гэж Гильом Де Рубрук номынхоо «Тэдний хүнс, өмсдэг хувцас» гэдэг долдуулгаар бүлэгт бичжээ.

«Мөнир хүн өлөр ч шүүдэ ч бух юмаа тавих газартай байдаг. Гутлыг ямагт срын хөлд, малгайг ямагт орны толгойд тавина. Иймээс малтай муу ч хөлд тавьдаггүй. Гутал сайн ч толгой дээр тавьдаггүй гэж ярьдаг» гэж К. Хэмфри тэмдэглэсэн нь монголчуудын зан заншлыг нарийн ажигласан хэрэг юм.

Судлаач Ц. Цэрэнгийн тэмдэглэсэнчлэн «Хүний хөлстэй малгай, өр аливаа хувцас өмсдэггүй» сайхан зашил манай ард түмэнд уламжлагдан ирсэн билээ.

1. 4. Хоол хүнсний эрүүл ахуй

«Зажилж идвлэл хоол болно, Залгиж идвлэл хор болно» гэдэг цэцэн уг нь хоолыг зажилж идэх нь шүдийг ажилд дасгалжуулж, хоодод гэдэсний ажиллагааг хөнгөвчилдэг төдийгүй хоолны найрлага дахь зарим хэсэг нь боловсрон гүсэнд орж хоолсанд наадахын таатай сээрэл огдог гэлгүйг өгүүлсэн бол «Яаравч явж идлэггүй» гэдэг үгэнд заруу сандруу, хөрсөн хүйтэн хоол идэх, их хоол идээд, идэнгүүтээ хэвтэж унtag нь хортойг тайлбарлажээ. Мөн гэдэсний халдварт өвчинүүд дамжин тарж болох замын тухай «Бадарч явсан газар балгатай. Батгана суссан газар өтгэй» гэх мэт өгүүлж, түүнээс сэргийлэх найдвартай арга бол «Бал баривал гараа долсоно. Бараг баривал гараа угаана» бохир зүйл барих бүрийдээ гараа угаах явдал гэж тун иновчтой өгүүлжээ. Хоол хүнсийн холбоотой өнөөдрийн өдөр хүртэл бидний зон-уilon гаргадаг алдааг «Нүдээ байхад нь үз. Шүдээ байхад нь зажил» зэрэг цэцэн угст тун иновчтой тусгажээ. Нөгөөтэйгүүр бид хоолыг хэмжээний хувьд тохируу-

лахгүй хэтрүүлж идэх тодорхой цаг баримтлахгүй ойр ойрхон иддэгийг «Гэм хийсэн гэдэс биш. Гэнэт олдсон хоол биш», «Гэнэт идвэл гэдсэнд цөвтэй. Гэнэт баяжвал насанд цээгтэй» гэж бодууштайг сануулжээ.

Монголчууд хоол ундандаа эртнээс олон нэр төрлийн бүтээгдэхүүн хэрэглэж иржээ. Де Карипини, Де Рубрук, Марко Пало нарын бүтээлдээ тэмдэглэснээр мал, төрөл бүрийн ан амьтны ма хэрэглэж, айраг тарааг тэр ч бүү хэл архи дарс, шар айрийг бүр ХII зуунд хэрэглэж байжээ.

«Тэд бүх төрлийн мал алгуулны махыг маш багаар хямгатай хэрэглэж гүруний айраг, ингэний сүү их хэрэглэдэг» гэж Де Карипини номынхоо «Хоол хүнсний тухай» бүлэгт тэмдэглэсэн байхад «Тэд өвлийн цагт цагаан будаа, шар будаа, арвай, зөгийн бал тэргүүтийн дарс мэт сайхан ундаа хийн».

Харин зуны улиралд гүүний айраг их хэрэглэх бөгөөд өөр төрлийн хоолонд нэг их санаа тавихгүй. Махыг жижиг нарийн зүсч, нар салхинд өлгөн «(тавин Г.Ц) хатаах ба тийнхүү хатаасан мах ямар ч эвгүй үнэргүй сайхан борц болно» гэж номынхоо «Тэдний иддэг хоол нь» гэлэг таалдугаар бүлэгт Де Рубрук бичжээ.

Харин Марко Пало бүтээлийнхээ долдугаар бүлэгт «Тэд бас өтгөрүүлсэн зуурмаг мэт болгосон хуурай сүү авч явах бөгөөд түүнийгээ усанд хутгаад задран уусахаар уудаг» гэж тэмдэглэснээс үзэхэд Монголчууд олон төрлийн хоол унд хэрэглэж бүр ХII зуунд хуурай сүү, шар айраг бэлтгэж байжээ.

Монголчуудын хосллох, ундахтай холбоогийн олон чухал дэг ёс байсныт Қеролайн Хэмфри тун нарийн ажиглаж: Монгол хүн гөртээ өөр өөрийн аягатай байдаг. Явуулын хүн аягатайгаа явдаг. Монголчууд дөрвөн аяганы хөөрьг долоодог. Өөрөөр хэлбэл цайны аяга, айрагны аягыг долоодоггүй, хоолны гяга, тарагны аягыг долоодог» гэж бичжээ. Ер нь хоолны болон тарагны аягыг долоох нь аягаа цэвэрлэх төдийгүй хэл залгнуурийн булчинг бэхжүүлж, хоолойн эзчинеес

сэргийлэхэд ч тустай гэж монголчууд үздэг ёс бий.

Судлаач Ц. Цэрэн нэр бүхий бүтээлдээ: Аяга барихдаа түүний амсар лээр хурууны ондгөө тавих, давуулахыг цээрлэдэг. Халуун хоол идээд хүйтэн ус уудаггүй» гэх мэт олон үнэтэй мэдээллийг тэмдэглэсэн нь бий.

Дээрх судлаач, эрдэмтдийн бичсэнээс үзэхэд монголчууд улирлын байдалд тохижуулсан холлодог, хоолны нарийн дэг, ёс горим баридаг байсныг олон талаас нь авч үзжээ.

1. 5. Сэтгэгэйн эрүүл ахуй

Монгол ардын цэцэн угзнд тухайлбал: «Бүгдээр хэлэлцвэл буруугүй. Бүлээн усаар угаавал хиргүй» гэх мэт бие биесээ ойлгон жаргал зовлонгоо хуваалцаж (гомдлыг эс гаргавал сэтгэлд зовлон, Бохирыг эс арилгавал биед зовлон), инээд хэрэй, баяр баясгалантай (Инээд зэтэй. Ханиад ханстай, Жаргалын дээд сэтгэл амар. Нөхрийн дээд үл атаархагч), уур уцааргүй сэтгэл тувшин (Мяндан гарах нарыг хөндөнгийн чул холтой. Хөөрхий хүний урийг уурын мунхат эвдэл сэтгэл тувшин явах нь эрүүл мэнд байхын эх булаг болох тухай (Сэтгэл сэтгүй бол таван махбод эрүүл, эсвэл Өрөмтос малаас, ёнго зүс сэтгэлээс гэх мэт) тус тус өгүүлж байна. Мөн энд сэтгэл тувшин байхад олон хүчин зүйл нелөөлдгэгийт (Бодоогүй бол бүү хэл, Болгоогүй идээнээс бүү амс гэх буюу уг хатуу ч явдалд тустай, эм гашуун ч өвчинд тустай эсвэл Уурласнаас хөгшрөх. Нийзэнээс идэрийн гэх мэт) учир шалтгааны гүн гүнзгий үндэстэй гаргажээ.

25000 гаруй жилийн түүхтэй, монголчуудын эрхэмлэн нэрлэснээр Будлаа Сүсүү бурханы шашинд «худал үл хэлэх, хов үл зөөх, омогтой ширүүн авир шунаг сэтгэлийг дарахыг сургасан нь ёнеө ч бидний эрхэмлүүштэй зам мөр билээ. (О. Дашибалбар «Бурханы мэлмийн» 1991)

Буддын сургаал ёсоор хүн нүрглийг бие, сэтгэл, хэл гурваар уилдэх бөгөөд үүний дотроос сэтгэлээр үйлдэснүүдээ хамгийн хүнд ажээ.

Эв зеийг хичээхийг монголчууд эртнээс эрхэмлэж байсны нэг тодорхой жишиэ бол Сүлэн эх хүүхдүүдээс эхийн удаад таван сум нэг

нэгээр нь салган өгч, дараагийн удаад таван сумаа нийлүүлж боогод өгч хугалуулж байсан тухай «Монголын нууц товчоон»-нд өгүүлсэн явдал юм.

Де Карпини өөрийн номын «Тэдний аятай зан авирын тухай» бүлэгтээ «Бие биесээ дориун хүндлэх бөгөөд өөр зуураа эвтэй найрсаас гэж монголчуудын тухай тэмдэглэсэн нь олзуурхууштай юм.

Кэролайн Хэмфри өөрийн өгүүлэлдээ: «Зочин хүн оройн хөхжилдээд үргэлжлэх түүх ярилдаг. Ялангуяа өвлийн шенийн ургад үлгэр домог сайн мэддэг настан байгаа алд эзэлжлен тойрч хөгшин, залуугүй үлгэр туульс сонсдог заншилтай» гэх мэтээр монголчууд өөр хоорондоо зэтэй найртай харилцдаг болон зав чөлөөтэй цагаа хэрхэн өнгөрөөдөг тухай тэмдэглэсэн нь бий.

Ийнхүү монголчууд зе эвийг хичээж, «Нэхрийн хэрэг бүтвэл, өөрийн хэрэг бүтнэ» гэж юуны урьдаар хүний төлөө санаа тавихыг нэн өрхэмлэдэг билээ.

1.. 6. Элдэв хорт зуршлын тухай Архи тамхины тухай зүйр цэцэн угэнд архи тамхинд дурлавал өвчин эмгэг олдог (Архи арван нас дараах Тамхи таван нас дараах гэх буюу архичны дотор ч хар, тархи ч хар г. м.) эмгэг олсноор наслах насаа хасдаг (Уушги мэнгэртэх тамхиних, ухаан балартах архиних гэх буюу Архинд тамхи хортой. Аминд хөбүүлаа хортой) тухай архинд орж тамхиний шунаасар эцэст нь хув чанараа гээдэг (Ханилсан нохраас холдуулдаг. Харгис дээрэнгүй сэтгэл төрүүлдэг. Хар архи хор идээ гэх буюу Архи уумтгай бол самуун болдог г. м) тухай тун өнөвчтой өгүүлжээ.

«Монголын нууц товчоо», «Алтан төвч», «Чингисийн есөн өрлөгчин ба ончин хүүгийн шастир» зэрэг XII—XIII зууны алдарт бүтээлжүүдэд «Барилдсан үгий минь байлгадаг бус уу? Бардам дээрэнгүй сэтгэлийг төрүүлдэг бус уу? (Монголын нууц товчоо 85 дугаар талд) гэх мэтээр архийг хэмжээ хязгааргүй хөрглэхийн учир холбогдлыг хэлэлцдэг.

Амны тамхи татах явдал XIX зууны эхээр монголд ихээхэн дэлгэрч тамхи худалдан авах зөргээр

илүү зардал сүйтгэл гарч байсан тул арвилаан хэмнэх зарчмыг дээд зэрэгээр баримталж, Цэцэнхан аймгийн хэбэй байгаад хожим чулган дарга болсон Тогтохтер (То ван) тамхи татах явдлыг бүр 1834 онд хориглон тушаал гаргаж байсан байжин дечин наснаас доош хүн архи ухыг хориглож байжээ.

К. Хемфри «Монголчуудын заншилдаэр дэч хүрээгүй хүн архи уудагч. Зарим газар санчигни нь үс бууралтаагүй хүн архи уудагч гээг» гэж тэмдэглэсэн бол судлаач Ц. Цэрэв «Эр хүн дэч хүрч байж сая архи амсдаг. Тавь хүрсэн хүн тавьж амс, жар хүрсэн хүн жаргаж амс гэдэг» гэж монголчуудын архи дарсыг тун нарийн дэг ёстой хэрэглэдэг байсныг тодруулж өгчээ.

1. 7. Хөдөлмөр амралтын дэглэмийн тухай

Хөдөлмөр амралтын дэглэмийн тухай цэцэн угст цагт захирагджас цагийг захирич сурахын эрүүл мэндийн болон бусад талын ач холбогдлыг (Багадаа сурахгүй бол бааханд даа сурахгүй гэх буюу Барс цагт эс босвол өдрийн явдал хоцорно. Багадаа эс сурвал настын явдал хоцорно, эсвэл Орой хариад хичээл тэхээс ороо хараад нойр хүрнэ» гэж өгүүлж, харин нойр цэнгэлээ богино байлгаж, нойроо гүйцэд авч байхыг «Өдлөхөд санах, сэрэх, уруудахад унтах, идэх хоёр гэх буюу Найр зугаа нойр алдах г. м сургамжилж, яаруу сандруу, босч, сууж идэлгүй, зэв хооллож «Яаравч явж иддэггүй. Жаргавч хэвтэж иддэггүй», хэрэв явган явбал түргэхэн алхалж «Явган хүн хурдандаа сайн» ундаа баахан хэрэглэж, булчин шөрмөсөө чангалж (Унтахыг хэмнэвэл ухаан сэргэнэ. Ундаа хэмнэвэл судас чангнара) байхын ач тусыг өгүүлжээ.

Бидний дээр өгүүлсэн «То вангийн сургаал»-д: «Биеийн амрыг харж дэний сууваас нойр хүрэн учтаад, аж төрөхийг алдах» гэж онцлог тэмдэглэсэн нь монголчууд ажил амралтын дэглэмийг хэзээнээс чанд баримталж байсны тод жижээ юм.

1. 8. Бие бялдрын хүмүүжлийн тухай

Монголчууд бие бялдрын хүмүүжлийг эрхэмлэн узэж, «Халаа

гаднаа хайраа дотроо» гэх юмуу «Эрхийг сурхаар бэрхийг сур» гэж хүүхэд багачуудыг балчир багаас нь бие сэтгэлийн тэнхээтэй болгохыг эрхэмлэдгээ билээ. Монголчууд эрт-нээс аливаа хүүхдийг моринд эрэмгийг, эрэгтэй хүүхдийг «Наадамд гурван даваатай» болгох зорилго тавьж, хүүхдийг борогшуулж чийрэгжүүлдэг байв.

Ойний энд жишээ татах байгаа цэцэн угст залуу нааснаасаа биенгэгтэй өөдтэй авч явбал эрүүл энх байхын гадна хүн ургэлж залуу, голо сайхан явдаг тухай (Залуу хүн биенийн өнөөр лягшин хүн хувцасны өмөөр), байгалийн элдэв үзүүлэлт биен дасган зохицуулж сурх (Хайрам хүйтэнд хацаараа хамгаалах тухай товч цэгтэй өгүүлжээ.

«Монголын нууц товчоо» номын 145 дугаар бүлэгт «Алтан товч» номын 27 дугаар талд Тэмүүжин тайчудад баригдаад оргон зугтааж, «Сноны гүнд орж хэвтээд» баригдалгүй гарч байгааг өгүүлсэн нь монголчууд усанд эрмэг, их мөрний усанд боловч хөвөж чаддаг байсаны харуулж байна.

ЭНКЕФАЛИН СИСТЕМ

Ю. ЖИНСМАА (АУИС биохимиин

Анагаах ухааны томоохон ололтын иэг нь хүнд опио-д сонгомол мэдрэгч хүлээн авуурууд (репентор) байдгийг тогтоож, хүний биед дотоод гаралтай (эндоген) опиогийн төрлийн пептидууд байдгийг нээсэн явдал юм.

Орчин үед энэ пептидийг судлах ажил өргөн хэмжээгээр хийгдэж судалгааны сонирхолтой баримт материал элбэгшиж байна.

Эрдэмтдийн анхаарлыг ихээр татах байгаа энэ пептидууд нь амьд биемахбодийн бүхий лүйл ажиллагаанд оролцно. Эдгээр бодис хүлээн авуурууд

Дэ Карпини «Монголчуудын түүх» номын 23 дугаар талд «Тэд сурхий тэвчээртэй, нэг хоёр хоног юу ч идээгүй хэрнээ өлсөж цангаж байгаа нь огт мэдэгдэггүй. Тэсгим хүйтэн, аагим халууны алинд ч морь унахдаа тун тэвчээртэй улс», Марко Палогийн «Хорвоогийн элдэв сонин» номын ерэн паймдугаар бүлэгт «Тэд явган элч нар гаргаж, иэг элч нь гурван бзэрий (1 бзэр — 1,5 км) газрыг туулах бөгөөд ийнхүү буухиачлан гүйснээр хорин өдөрчийн газрыг хоёр өдөрт туулдаг байсан» гэх мэтээр монголчуудын бие бялдрын хүмүүжлийн талаар бичиж тэмдэглэсэн нь олонтаа.

ДҮГНЭЛТ

Өмнө өгүүлснээс дүгнэж хэлэхэд монголын ард түмэн Дорно дачини соёлт түмний нэг адил албаны соёлын түүний дотор ариун цэврийн соёлын арвиin баян сантай бөгөөд энэ их өвийг тусгайлан авч, нарийчлан судалж, үр хүүхэддээ өвлүүлж үлдээх, уг өв соёлыг соёл иргэншилийн өнөөгийн түвшинд шинчлэн баяжуулах нь бидний эрхэм үүрэг юм.

Багш)

тай (репентор) холбогдох морфинтой адил нөлөө үзүүлэхээс гадна сэтгэл хөдлөл, тогтоохой, ухаан болон биений дулаан, цусны даралтын зохицуулгад олсон талын нөлөө үзүүлдгийг тогтоожээ.

Иймээс эдгээр пептидийн үйлчлэх механизмыг судлах нь опио төст бодисыг эмчилгээний зорилгоор хэрэглэх боломжийг олгох практикийн чухал ач холбогдолтой юм.

Опио төст пептид нь препро-энкефалин, препродинорфин, преопиомеланокортин гэж гурван бодисоос үүсдэг гэж үзэж байна. (4)

Опио төст пептидийн гол төлөлөгч болох энкефалин нь дээрх гурван бодисын задралын бүтээгдэхүүн юм. Жишээ нь: аденогипофизын уураг проопиомеланокортин ($M=31\,000$; :300 аминхүчлийн улдэгдлээс тогтсон) задарч бета-липотропин үүснэ. Бета-липотропиноос альфа, бетта, гамма эндорфин, мет-энкефалин үүснэ.

Энкефалин нь таван аминхүчлийн улдэгдлээс тогтсон нэгдэл юм.

Тухайлбал: мет-энкефалин
Тир—Гли—Фен—Мег
лей-энкефалин

Тир—Гли—Фен—Лей
гэсэн бүтэцтэй байдаг.

Бие махбодид энкефалины тархалт янз бүр байдаг. Опио төст пептидуудээс энкефалин төв мэдрэлийн тогтолцоонд их хэмжээгээр байдаг.

Мет-энкефалин сүүл хэлбэрийн бөөмд (стриатум), бөмбөлөг хэлбэрийн бөөм (гипоталамус) зэрэгт 1 мг уурагт 5 имоль, их тархины бор гадарга, таламус, гипокампад 1—2 моль, харин бага тархинд 0,2—0,0 имоль/мл байна.

Лей-энкефалин нь тархалтын уувд мет-энкефалинтай адил тэдрэлийн тогтолцоонд их хэрээ хэмжээгээр гурав дахишлага байдаг.

Энкефалин төв мэдрэлийн огтолцоноос гадна хүний бийн бусад эд эрхтэн, хodoод эдэсний хучаас эдэд бий. Цусны сийэнд мет-энкефалин 0,05—0,1 мполь) мл хэмжээтэй байдаг.

Гистохимийн судалгаанаас үзэхэд тархинд энкефалин нь

холин, корадреналин, дофамин зэрэг медиаторуудыг агуулсан мэдрэлийн эсийн цитоплазмд байдгийг тогтоожээ.

Судлаачдын анхаарлыг их татаж байгаа нэг асуудал бол опио төст пептид эд эстэй хэрхэн үйлчилдэг механизмыг тогтоох явдал юм. Рецепторыг нээсэн явдал нь эм судалалын түүхэнд том ололт болсон юм.

Биохимиийн болон эм судалалын судалгаанаас үзэхэд амьтны тархинд опио төст бодистой үйлчлэлцэх мю, каппа, дельта, сигма рецепторууд байгааг тогтоожээ. Рецептор бүр нь тодорхой бодистой (лиганд) холбогддог бөгөөд эрхтэн тогтолцооны үйл ажиллагаанд өөр өөр нөлөө үзүүлдэг. Тухайлбал: мю-рецептор нь морфинтой, дельта нь энкефалинтай байхад, каппа-рецептор нь диморфинтой, сигма-рецептор нь алилнометазоцинтай холбогддог.

Үйлчлэлийн хувьд мю-рецептор нь өвчин намдаах, амьсгалыг боох үйлчлэлтэй, каппа-рецептор нь мэн өвчний намдаах, тайвшруулах, сигма-рецептор нь хий үзэгдэл, амьсгал давхцуулах, дельта-рецептор нь сэтгэл хөдлөлийн процесст нөлөөлдөг гэж үзэж байна. Опио төст пептид нь нейромодулятор, нейромедиаторын уурэг гүйцэтгэнэ.

Энкефалины үйлчлэх механизмыг бүрэн тогтоогоогүй байгаа гэж үзэж болно. Энкефалин мэдрэлийн эсийн натрий ионы нэвчих чанар болон эсийн зохицуулгад гол уурэг бүхий цагирагт нуклеотидад

нэлээлдөг гэж үзэж байна. Мэн энкефалины үйлчлэл тархины биогены мономинуудтай няйт холбоотой.

Медиатор (ацетилхолин, дофамин, серотонин, норадреналин, ГАМК, гиотамин) болон опио төст пептид бие биедээ харилцан нэлээлдөг. Эдгээрийн харилцан үйлчилгээ нь цагирагт нуклеотид, кальцийн ион, простогландиниас шалтгаална. (1).

Эндоген гаралтай опио төст пептид нь мэдрэлийн эдэд *in vivo*, *in vitro* нөхцөлд нейромедиаторын нэгэн адил ялгаран гарна. Ийнхүү ялгарах механизм нь калийн ион, кальцийн ионаос хамаардаг.

Хүний бие махбодид дотроосоо ууссан (эндоген) пио пептидийн задрал нь энкефалинаминопептидаз, энкефалиназ А, В. зэрэг ферментүүдийн нэлөөтөөр явагдана.

Тир—Гли—Гли—Фен—Мет

Энкефалинаминопептидаз энкефалиназ А. Опио төст пептидийн үйлчлэл нь эдгээр ферментээс хамаардаг. Тухайлбал: энкефалиназ А, аминопептидаз ферментийн нэлөөгөөр буурна. Иймээс хоёр фермент энкефалини солилцоонд хамгийн гол үүрэг гүйцэтгэдэг гэж үздэг.

Одоо эрдэмтдийн анхаарлыг татаж байгаа өөр нэг зүйл нь энкефалины төрлийн бодисыг (аналог) цэврээр гаргаж авч эмнэлгийн практикт ашиглах явдал юм. Нийлэгжилтийн аргаар гаргаж авсан энкефалины төрлийн бодис нь:

1. Биологийн орчинд тогтвортой,
2. Рецепторуудтай холбогдох чадвартай,
3. Эсийн дотор нэвтрэн орох чадвартай байх зэрэг тодорхой шинж чанарыг зайлшгүй хадгалсан байх ёстой.

Орчин үед энкефалины төрлийн бодисыг гаргаж авах талаар зарим тодорхой ахиц олж хэд хэдэн төрлийн бодисыг гарган авчээ. Эдгээрийн дотроос эдүгээ хамгийн өргөн судалж байгаа нь даларгин юм. Энэ нь ходоодны шархлаа, сэтгэлтүгшлийн (стресс) өвчнийг эмчлэхэд зэрэг үйлчлэл үзүүлэх боломжтойг тогтоожээ.

Сүүлийн үеийн судалгаанаас үзэхэд даларгин нь гэмтлийн шокийн эсрэг нэлөө үзүүлж байна. Энэ нь цусны эргэлт, эдийн солилцоог сайжруулдаг. Үүний зэрэгцээ зүрхний агших идэвхийг бууруулах сөрөг нө-

энкефалиназ В энкефалиназ А. Опио төст пептид дотоод шүүрлийн булчирхайтай харилцан уялдаа холбоотой гэж үзэж байна.

Хүний сэтгэл түгшилтийн урвалд чухал нэлөөтэй, гипоталамус, гипофиз, бөөрний даавар булчирхайн системтэй ямар холбоотой болох нь эрдэмтдийн анхаарлыг онцгой их татаж байна. Энэ талын судалгаа нь цаашид тэдгээрийг эмчилгээнд хэрэглэх боломжийг илрүүлэх нь зайлшгүй.

Опио төст тогтолцоо нь амьд бие махбодид явагдаж байгаа

ихэнх процесст оролцдог. Иймд энэ тогтолцоог судлах, ялангуяа энкефалины төрлүүдийг гарган авах, тэдгээрийн үйлчлэх механизмыг тогтоож улмаар эмчилгээнд хэрэглэх явдал орчин үеийн анагаах ухааны өмнө зогсож байгаа нэг чухал асуудал юм.

АШИГЛАСАН ХЭВЛЭЛ

1. В. М. Булаев, М. С. Раевский, к. Услехи физиол. наук. 1982. т—13, № 2 с—65—92

2. Е. В. Голанов, Современное состояние проблемы эндогенных морфиноподобных веществ — М. Медицина, 1986, С. 75

3. Г. К. Золоев, ж. Пат. физиология. 1988 № 2

4. Э. Коста, М. Трабуки Эндорфины. М. Мир 1982 С. 368

5. В. Г. Смирнов, В. А. Виноградов, С. А. Булгаков, Лиганды опионных рецепторов. Гастроэнтерологические аспекты. М. Наука. 1983

6. Е. И. Чазов, М. И. Титов, В. А. Виноградов, В. Г. Смагин, В. Н. Смирнов, ж. Вопросы медицинской химии. 1984. № 3.

Асуудал дэвшиж байна

МОНГОЛ УЛСЫН ХҮН АМ ЗҮЙН ТҮҮХЭН ХӨГЖЛИЙН ҮЕ ШАТЛАЛЫН АСУУДАЛД

Ч. ДОНДОГ

Хүн ам зүйн явцын түүхийг судлах нь зөвхөн танин мэдэхийн холбогдолтой төдийгүй тэдгээрийн хөгжлийн дэс дарааллын схемийг боловсруулах, төрөлт, нас баралт, гэрлэлт, салалт гэх мэт хүн амын ходлөлгөөний зарчмын үндсэн чиглэл, зүй тогтлыг тодорхойлоход чухал ач холбогдолтой.

Манай орны хувьд хүн гэдгээ танин мэдэхгүй, хүнгүйгээр олон жил явсны зовлон одоо амсаж байна. Энэ ч учраас манай оронд хүн ам маань ямар түүхэн замыг туулж яаж өөрчлөгдж ямар хэлбэрээс ямар хэлбэрт шилжиж ямар бэрхшээлийг туулав, цаашид ямар бэрхшээл тулгарах, тухайн асуудалд (хэрэв тооны хэтийн төлвийг эс тооцвол) төсөөлгөөгүй байна.

Аймгуудын хүн ам нийгэмтүүхийн хувьд 2 үндсэн нөхөн

Р. Пресса Народонаселение и

үржихүйн замаар явж, нэг хэсэг аймгийн хүн амын төрөлт буурах хандлаганд, нөгөө нь эсөх хандлаганд байна.

Улсын хэмжээнд авч үзвэл жилд 80000 хүн төрж 18000 хүн нас барж байна.

Энэ учраас түүхэн дэс дарааллын судалгаа нь нөхөн үржихүйн нэг дэглэмээс эхлэн төрөлт, нас баралтын өөрчлөлийн нэг хэсэг үеийг дамжиж нөгөөд шилждэг болох нь бидний сонирхол татах байна.

Дайны дараах жилүүдийн ном сударт «хүн зүйн шилжилт» гэж нэрлэсэн байна. Түүний зарчмын мөн чанар бол хүн ам өөрийн хөгжлийн дэтор эхлээд «эгэл дэглэм» (regime primitive naturelle)-ийн шатыг дамжиж дараа нь төрөлт нас баралтын янз бурийн түвшинтэй тодорхой дэс дараалтай З үе шатлал (фаление и ее изучение, стр. 73.)

за)-ыг дамжсан байна. «Эгэл дэглэмийн» ўе шатанд хүн амын олонх нь төрөлтийг хорогдуулахгүйгээр бараахгүй төрөлтийн ерөнхий үзүүлэлт (40—45%) өндөр түвшинд байдаг. онцлогтой. Нас баралт ч мөн өндөр түвшинд орших бөгөөд хүн амд үзүүлэх эмнэлгийн тусламж огт байхгүй учир билембодийн төрөлхийн бат бэх чанартай тийм хүмүүс үлдсэн байдаг. Тухайлбал «тайван жилүүдэд» (тахал, өлсгөлөн, дайн дажингүй уед) ч нас баралтын ерөнхий үзүүлэлт 30—35%-ийн хэмжээнд байхад харин тахал гараад ирэхээр иэмзгддэг.¹

Энэ учраас хүн амын тоо аажим өсүү жилд дунджаар 1%-ийн удаан хугацаат өсөлт үргэлжилдэг.

Энэхүү ўе шатны дараа хүн ам зүйн жинхэнэ шилжилтийн аинхны шатлал эхэлж хүн амын нөхөн үржихүй (төрөлт, нас баралт) урьдах шинж чанараа хадгалж төрөх чадвар физиологийн дээд түвшинд хүрч анагаах ухааны тусламжийн үр дүнд халдварт өвчинүүд харьцангуй хурдан буурдаг.

Аинхны шатанд хүн амын оргөтгөсөн нөхөн үржихүй үргэлжилсээр хүн амын жилийн дундаж цэвэр өсөлт 2,5—3% байдаг байна.

Хоёрдугаар шатлалд нийтлэг шинж чанартайгаар ухамсартайгаар хорогдуулах үйл ажиллагаа явуулснаас төрөх чадвар түргэн буурч эхлэхийн зэрэгцээ арай суулд хүүхэд олохыг зохицуулдаг. Нас баралт буурсаар байх боловч

түүний хурд нь төрөлтөөс аажим байдаг. Хүн амын өргөтгөсөн нөхөн үржихүй хэвээр байх бөгөөд харин цэвэр өсөлтийн хурд буурдаг.

Гуравдугаар шатлалд төрөлтийг зохицуулах асуудал хүн бурийн практик зүйл болж төрөлгийн түвшин нийгмийн анхаарал татсан зүйл болоогүй нөхцөлд бага зэрэг буурдаг. Ихэнх халдварт өвчнийг устгасны дараа нас баралтын түвшин практикийн хувьд бараг өөрчлөгддөггүй, харин тэр нь ихэнх тохиолдолд төрөлтийн түвшингээс бага байдаг. Хүн амын цэвэр өсөлтийн дундаж хурд (төрөлтийн өөрчлөлтөөс хамаарахгүй) 0,5—1,0% болж хүн амын нөхөн үржихүй өргөтгөсөн хэвээр байх боловч нэг хэсэг тохиолдэлд энгийн чиглэлтэй байснаа дараа нь төрөлт хурдан буурч нарийсаж эхэлнэ.

Хүн зүйн шилжилтийн зарчмын «ангилалын» схем нийм байх болно. Хэрэв хүн амын нөхөн үржихүйн (эхний ўе шат) нэгэн төгсгөлд хүн амын амьдралын ариун цэврийн доогуур түвшинг илэрхийлэгч төрөлт физиологийн өндөр хязгаарт ойрхон, нас баралт өндөр байдал гарч ирэхэд нөгөө төгсгөлд нь нийгэм эдийн засгийн олон хүчин зүйлийн нөлөөгөөр төрөлт буурч байхад нас баралт (амьдралын нөхцөл сайжирч ариун цэврийн соёл нэмэгдэх) мөн буурдаг.

Эдгээр ерөнхий хэмжээ нь хүн ам зүйн түүхийг бодитойгоор харуулдаг амьд шалтгуюур юм. Гэвч түүхийн бо-

лон эдийн засгийн өвөрмөц нөхцөлүүд дээр дурьсан дэс дарааллтай шатлал, шилжилтийн хурдыг өөрчилж болно.

Судар номуудад бичигдсэнээс үзвэл янз бурийн улс орнуудад алинд ч хэрэглэж болох шилжилтийн хэд хэдэн хувилбар байдаг ажээ.

Тухайлбал: Английн, Францын, Япон-Мексикийн гэсэн шилжилтийн төрөл юм.

Нэгдүгээр ба хоёрдугаар шатлалд хүн зүйн шилжилтийн Английн хэлбэр сонгомол схемд ойрхон байдаг.

Францын нь шилжилт нэгдүгээр шатлалаас эхлээд төрөлт буурч эхэлдэгээрээ Английнхаас ялгаатай.

Харин Япон-Мексикийн хэлбэрийн онцлог гэвэл нэгдүгээр шатлалаас эхлээд л нас баралт хурдан буурч байхад анагаах ухааны болон нийгмийн бусад хүчин зүйлийн илрэеgeэр төрөлт өндөр байлаг. Үүний үр дүнд хүн амын эсөлт маш өндөр хурдацтай байна. Гэвч гуравдугаар шатлал хүн ам зүйн шилжилтийн бүх хэлбэрт практикийн хувьд ижил төрөл юм.

Энэ схемийг олон оронд ялангуяа европын орнуудад хэргэглэсэн юм. Тийм төрлийн судалгаанууд бусад орнуудын хүн ам зүйн явцын дэс дарааллыг судлах үндсэн дээр ирээдүйн зүйг ямар нэг хэмжээгээр тэсөөлөх боломжийг тодорхойлсод чухал. Энэ уттараа мэндэй орны хувьд дээрх төрлийн судалгаа ихээхэн соширхолтой байна.

«Эгэл» гэж нэрлэж байгаа анхны шатанд хувьсгалын өмчих Монголын хүн амын хөг-

жил бусад орны адил төрөлт (40—45 промели) өндөр байгаагүй бөгөөд харин нас баралт (30—35 промели) адилхан өндөр байсан юм. Энэ үед хүн амын эсөлт зогсонгүй буюу буурах зах хязгаарт тулж ирсэн байна. Хүн амын тоо 1808 онос 1918 он хүртэлх хугацаанд 4,5%-иар буурсан тухай судалгааны материалд бий. (Д. Цагаанхуугийнхээр)

Оросын эрдэмтэд Сережников, Майский нарын судалгаагаар төрөлт 20 промели нас баралт 30 промели, хүүхдийн эндэгдэл 500 пролени, эхийн эндэгдэл 130 промели, төрөж насны эмэгтэйчүүдийн 1/2 нь ямар нэг арьс өнгөний өвчтэй, амьдрал ахуйн нөхцөл маш хүнд, соёл, ялангуяа ариун цэврийн соёл маш доогуур үтамжлалт эмнэлгийг эс тооцвол эмнэлгийн байгууллага, шинжлэх ухааны эмнэлгийн боловсон хүчин байхгүй байлаа.

Хүн ам зүйн түүхэн хөгжлийн явц, хүн амын тооны өөрчлөлт зэрэг нь тухайн улс орны түүхэн хөгжил, болсон үйл явдалтай нарийн уялдаатай байдгийг дараах «Монгол улсын хүн ам зүйн түүхэн хөгжлийн учэлэлээс» харж болно.

Монгол улсын хүн амын тооны динамикт задлан шинжилгээ хийж үзвэл нийгэм-эдийн засгийн түүхэн хөгжлийн янз бурийн үеүдээр нөхцөлдсөн ерөнхийдөө таван (үе шатлал) чиглэл тодорхойлогдож байна. Жишээ нь:

I үе шат Хүн-нугийн үе
II үе шат Эзэн Чингисийн нэгдсэн төрийн үе

III үе шат Юуань улсын хаанчлалын задрах үе (1500 он хүртэл)

IV үе шат бол жижиг бутархай, тус бурдээ жижиг хэлбэртэй хуваагдан задарсан задралын үе, хятад манжийн дарлал (1500—1911)

V үе шат Ардын хувьсгалын дараах (1921 оноос хойших үе гэж ерөнхийдөө хуваагдаж

байна. Харин Ардын хувьсгалын түүхэн хөгжлийг дотор нь

Ү. 1. 1921—1940

Ү. 1. 1. 1921—1930

Ү. 1. 2. 1930—1940

Ү. 2. 1940—1990

Ү. 2. 1. 1940—1950

Ү. 2. 2. 1950—1990

Ү. 3. 1990 оноос хойших үе гэж хувааж болно.

ЗАХ ЗЭЭЛ ЭМЧИИН ЕС СУРТАХУУН

И. САНЖААДОРЖ (АУИС)

Үндсээрээ өөрчлөгдөн шинэчлэгдэж байгаа эдийн засаг, улс төр, нийгмийн олон асуудал жам ёсоороо хөгжлийнхөө хэвийн замд баттай орж, эрүүл мэндийн албаны зохион байгуулалт, материаллаг бааз, үйлчилгээний технологи болон стронгийг болж байж л эмчилгээ үйлчилгээний чанарт мэдэгдэхүйц өөрчлөлт гарах нь дамжиггүй. Харин энэ өөрчлөлт шинэчлэлийн үеийн түр зуурын бэрхшээл, эмнэлэг үйлчилгээний олон хэвшил, хүмүүсийн харилцааны цоо шинэ тогтолцоо бүрэлдэж буй өнөө үед эмчийн ажлын амжилтыя гол хөшүүрэг болсон эмчийн ёс суртахуун, деонтолог, алдарт Гиппократын болон монгол улсын хүний их эмчийн тангараг ямар нэг хэмжээгээр мартагдчихвий гэсэн зүй ёсны болгоомлолыг төрүүлж байна. Манай зарим эмч нараас өргөсөн тангарагаасаа няцах, хууль эрх, ёс суртахууны зөрчил гаргах мэргэжлээ ажил амьдралын жинхэнэ хэрэгцээ болгоогүйгээс ёмчийн ёс суртахууны зөрчил гаргах

яvdal цөөнгүй тохиолдож байна.

1992 онд зөвхөн Улаанбаатар хотод 200 шахам эмч, эмнэлгийн дунд мэргэжилтэн мэргэжлийн бус ажил эрхлэхээр ажлаасаа гарснаас гадна улсын захиалга, зардлаар суралцаж эмчийн мэргэжил эзэмшихээд томилсон газар очихгүй байгаагаас одоогийн байдлаар олон сумын малчид, хөдөлмөрчид сумандaa их эмчийн тусlamж авч чадахгүйд хүрч байгаа юм байна.

Улсын шүүх эмнэлгийн магадлах товчоогоор суулийн жилүүдэд шалгагдсан 150-иад «эмчийн хэргийн» тал хувь нь оношлогоо, эмчилгээ технологи, тактикийн алдаа гаргаснаас гадна эмчийн ёс суртахуун, эмчийн өөрийн нь буруу үйл ажиллагаатай холбоотой «иатрогены эмгэг» алдаа нийлээд хувийг эзэлж байна. Үрд нь эмчийн харьцааны соёл, эв зүй, сэтгэлийн тэнхээтэй холбоотой алдаа зонхилж байсан бол суулийн үед хувийн ашиг хонжоотой холбоотой гарах деонтологийн

алдаа нэмэгдэх төлөвтэй байгаа нь улам ч илүү сэтгэл зовоож байна.

Зах зээлд алив нэг үйлчилгээ нь таваар мөнгөний харилцаанд тулгуурлан хөгждэг жамтай болохоор улсаас хувийн хэвшлийн эмнэлгүүдийн үйлчилгээнд оролцогч хоёр талын сонирхол, эрх ашигийг харилцан хамгаалж, баталгаажуулах нь зүйд нийтэх боловч манай зарим эмнэлгийн байгууллага, эмч ажилчид бүхнийг хөрөнгө мөнгө, ашиг хонжоо шийдвэрлэх мэтээр өрөөсгөл ойлгож богино хугацаанд өвчтөний халаасыг хоослох аргад «суралцаж» байгаа нь анхаарал татаж байна.

Зарим эмч эм зүйчид өөрийн мэргэжлийн дагуу хийх ёстой оноши эмчилгээний үйлдэл, арга бэлдмэлээ хэт магтан «нээлт» хийсэн мэт шуугуулах нь эмчийн деонтологт харш зүйл бөгөөд энэ нь зах зээлд байх шударга өрсөлдөнийг гажуудуулахад хургэж байна.

Зах зээлийн нөхцөлд хээл хахууль, өргөл барьц авч өгөх нь төдийлөн анзарагдахгүй болж буйг ч анхаарч хуулийн заалтыг тодорхой болгох шаардлагатай болжээ.

Хүний хамгийн нандин эрдэнэ эрүүл мэндийг мөнгөөр хэмжиж эд бараа адил үнэхаялцуулах худалдаанд оруулж болохгүй нь тодорхой билээ. Үйлчилгээ нь нэгээнт төлбөртэй болохоор хөнгөн шалмаг, оновчтой аюулгүйн баталгаатай хүнийг бодитойгоор эрүүлжүүлсэн, урт наслуулсан байх

бөгөөд хэрвээ эмчилгээний үр дун нь хангалтгүй болбол дээрх байгууллагуудын оролцоотойгоор эргэж төлбөрийн тооцооч хийдэг байна. Оны эхний Зулиралд Улаанбаатар хотод ажиллаж байгаа хувийн эмнэлгүүдэд 120000 хүнийг үзэж эмчилсэнээс тавны дөрвөн хувь нь эдгэрсэн буюу сайжирсан гэсэн мэдээ байгаа нь бодитой бол муугүй үзүүлэлт юм. Гагцхүү ямар шалгуураар дээрхийг батлах вэ? Манай оронд «шинжилгээ оношлогоо, эмчилгээний чанарын стандарт»-ыг яаралтай боловсруулж мөрдөх шаардлагатай болжээ.

Иргэд үзүүлэх эмчээ түүний мэдлэг, авьяас, чадавхи ёс суртахууны хүмүүжлийг харгалзан чөлөөтэй сонгох эрхтэй болж байгаагаас эмч аль ч талаараа «гологохгүй» байх шаардлагатай болжээ. Хүний их эмч бэлтгэдэг их сургуульд сайн, муу гэж хоёр туйлд хувваагдан үнэлэгдэх эмч бэлтгэмээргүй байна. Эртний төвдөд муу буюу дунд эмчийг эмч гэж тооцдоггүй байсан нь эмч хүнд ямар их ондер шаардлага тавьж сайны сайн нь эмчийн ажил эрхлэх эрх олж авдгийн баримт мөн,

Сүүлийн үед «тус болохгүй бол хор бүү хүргээч» гэдэг эмчийн деонтологийн нэгэн чухал заалт зөрчигдсөнөөс өвчтөнд шинэ эмгэг (иатрогени эмгэг) бий болгох тохиолдол цээнгүй гарч байгаа нь иууц биш юм. Эмгэгийг эмчлэн илааршуулдаг эмч өөрөө шинэ эмгэг үүсгэжээ гэхэд хүн эрэлзэж гайхах биз! Гэвч үнэн,

Байдал ийм байна. Олон улсын өвчлөлийн ангилалд бие даасан эмгэгийн нэршилд оруулсан иатрогени эмгэгийг манай орны нөхцөлд тусгайлан судлах, түүнээс урьдчилан сэргийлэх арга замыг тогтоох шаардлагатай болжээ.

Манай оронд эмч эмнэлтийн ажилчдын үйл ажиллагаанд мэргэжлийн хяналт тавих систем боловсронгуй бишээс хөдөлмөрчдийг чирэгдүүлсэн, хохиросон олон асуудал (онош эмчилгээний чанар стандартын зөрчил, иатрогени эмгэг г. м) хуулиар хэлэлцэгдэх хэмжээнд хүрээтгүй гэдэг нэрээр шүүн хэлэлцэгдэхгүй онгөрөх явдал цөөнгүй гарч байна. АНУ-д эмнэлэг үйлчилгээнд хяналт тавих хуулийн биш албыг хөгжүүлэхэд ихээхэн анхаарч оролцогч хоёр талын эрх ашгийг хөндсөн асуудлыг шийдвэрлэхдээ үнэнхүү хариуцлагатай ханддаг учраас тэр албаны нэр хүнд хүн амын дунд ямагт өндөр байдаг байна. Тэнд хөдөлмөрчдийн зүгээс тавих хяналт ч сайн байдаг байна.

Эмчийн ёс суртахуун деонтологийн зөрчлийг илрүүлэх, шүүн хэлэлцэх бусдын алдаан дээр суралцах ажлыг зохион байгуулах үүрэгтэй «үнэний» «нэр төрийн» шуухийг эмнэлэг тус бүр дээр байгуулж байнтын удирдлагаар хангаж ажиллуулах шаардлагатай юм.

Нийгмийн хуучин тогтолцооны үед эрүүл мэндийн байгууллагаас алдаж оносон зүйл багагүй байсан ч энэ хугацаанд бидний бага ч болов Олсон нэгэн амжилт бол ёс

суртахууны өндөр чадвартай олон арван эмч бэлтгэсэн явдал мен. ЗХУ (хуучин нэрээр)-аас уригдан ирж ажиллаж байсан өндөр мэдлэгтэй, сайхан сэтгэлт олон арван орос эмч нарын дүр төрх, гавьяат үйлс өнөө ч бидний зүрх сэтгэлд хадгалагдаар... Ахмадуудынхаа энэ сайхан чанар, уламжлалыг гээчихгүй хойч үедээ залгамжлуулан үлдээх юм сан.

Эмнэлэг-шинжлэх ухаан урлаг, эв дүй, туршлагын нийлбэр цогц бөгөөд зарим эрдэмтэд эмнэлгийг туршлагын шинжлэх ухаан ч гэдэг. Бид туршлагатай олон арван эмчээ тэтгэвэрт яаран гаргасан нь юу л бол? Харин зарим өндөр мэдлэг, туршлагатай эмч нар маань өндөр хангамж, цалинтай өөр ажлын «дуудлаганд» хувийн ашгаа урьдал болгож автагдаагүй нь тэдний эмчийн ёс суртахуун хүмүүжилтэй холбоотой биз. Орчин үед эмчийн ёс суртахууны олон асуудал шинэ төвшинд тавигдах болж түүний агуулга хэлбэрт ч өөрчлөлт гарч байна. Гухайлбал хүн «амьд байх» эрхтэйгээс гадна «үхэх» эрхтэй «сайн үхлийн» тухай өргөл барьц, шан харамж, хээл хахууль, эмчийн нууц иатрогени эмгэгийн тухай олон ойлголтыг тодотгох, шинэ тайлбар өгөх улмаар нийтээрээ шүүн хэлэлцсэн ч болох юм.

Эмчийн ёс суртахуун деонтологийн мэдлэг хүмүүжлийг мэргэжлээс дутуугүй үнэлж түүнийг дээд шутээн болгох цаг болжээ.

Судлаач сонгон авсан ургамлын бүх талын фитохимиийн судалгаа явуулж ортуузын төрлийн ургамалд пиридиний үлдэлтэй фенинилэтил амины уламжлал байдгийг анх удаа шотолсны зэрэгцээ нийт флавоноидын тооны тодорхойлолт хийх спектрофотометрийн аргачлал боловсруулж, рутин гаргах авах шинэ эх үүсвэр тогтоосон байна.

6. Н. Удвал

Сэдэв: Бага насны хүүхдийг диспансерчлах эмнэлэг зохион байгуулалтын асуудлууд

Хаана, хэзээ хамгаалсан: 1992 оны 5 дугаар сарын 7 Улаанбаатар

Судлаач судалгаандаа бага насны хүүхдийн эрүүл мэндэд нөлөөлөх нийгэм ахуй, нийгэм биологи, эмнэлэг зохион байгуулалтын зэрэг олон хүчин зүйлийг анализын артаар судлан тогтоож, бага насны хүүхдийн дунд олонтоо тохиолдох сульдаа, тэжээлийн доройтол, цус барагадалт, хоол боловсруулах болон амьсгалын эрхтнүүдийн өвчнүүдийн өртөмтгийн хүчин зүйлийг Вальдын дэс дараалсан анализын аргаар тогтоож, бага насны хүүхдийн өвчлөлийн түвшин, бүтцийг судалсан байна.

Судалгаандаа амбулатори, поликлиникээр хүүхдэд үзүүлж байгаа эмнэлгийн тусламжийн зохион байгуулалтын хэлбэрүүдийг харьцуулан «Өрхийн эмнэлэг үйлчилгээг хэрэгжүүлэх» үзэл баримтлал дэвшүүлжээ.

7. Лувсан-Ишийн Ажнаай — Анагаах ухааны их сургуулийн эмнэлгийн биофизикийн тэнхимийн багш.

Сэдэв: Пүсны улаан эсэд хэт ягаан туяаны нөлөө.

Хэзээ, хаана хамгаалсан: 1992 оны 5 дугаар сарын 15 Улаанбаатар

Судлаач — Энэ бүтээлдээ сүүлийн үед ихээр сонирхогдож буй нусыг хэт ягаан туяагаар туяажуулж эмчлэх эмчилгээг лабораторийн туршигын зэрэгцээ цусны улаан эсийн агрегаци, түүний бүрхүүлийн болон сийвэнгийн липидийн үл исэлдэх чадвахи, цус хайлах зэрэгт, хэт ягаан туяаны нөлөөллийг судалжээ.

Ургэмжлэл нь № 4-т.

МОНГОЛЫН АНАГААХ ҮХААН СЭТГҮҮЛИЙН ЦЭЦИЙН ГИШҮҮД

П. Нямдаваа (өрөнхий эрхлэгч), **Б. Дэмбэрэлл** (орлогч эрхлэгч), **Г. Дашзэвгэ** (орлогч эрхлэгч), **Ш. Доржжадамба** (орлогч эрхлэгч), **Г. Пүрэвдорж** (хариуцлагатай нарийн бичтийн дарга) **Р. Арслан Ж.** Батсуурь, **Б. Гоош**, **А. Ламжав**, **Э. Лувсандаагва**, **А. Өлзийхутаг**, **Т. Тойвгоо**, **Ц. Хайдав**, **Ж. Шагж**, **Г. Цагаанхүү**

ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮД

С. Алтан (АНУ Нью-Жерси), **Д. Балдандорж**, **Б. Банзар**,
М. Грэйт (АНУ, Миннесота), **Б.Дагвацэрэн**, **Ж. Дашдаваа**,
Б. Доржготов, **Б. Жав**, **Ш. Жигжилсүрэн**, **Г. Зориг**, **Т. Зориг**,
Г. Лувсан (ороосын холбоо - Монгола) **Д. Малчинхүү**,
Н. Мөнхтүвшин, **Ц. Мухар**, **Б. Нацагдорж**, **Н. Норовпил**,
Ч. Нээчин, **П. Онхуудай**, **Э. Нурувдаваа**, **Б. Рагчаа**, **Э. Санжаа**, **Г. Сүхбат**, **С. Цоодол**, **Л. Шагдар**

**МАНАЙ ХАЯГ УЛААНБААТАР 210648
ЧИНГИСИЙН ӨРГӨН ЧӨЛӨӨ «ЭРҮҮЛ ЭНХ»
ХЭВЛЭЛИ Н ГАЗАР. УТАС: 321307**

Техник редактор **Ө. Бямбажаргал**

Хянаагч **Г. Батчулуун**

Өрөлтөнд 1993 оны 10 сарын 5-нд

Хэвлэлтэнд 1993 оны 12 сард

Цаасны хэмжээ 60x90 1/16

Хэвлэлийн хуудас 3.0 С—99 Сүхбаатар компанийд хэвлэв.